

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА****2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр, Пүрэв гараг****Хуралдааны тэмдэглэлийн агуулга****Хуралдааны товч тэмдэглэл:**

1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

6-44

**1.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон
Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн
тайлан**

7-24

**2.Монгол Улсын 2026 оны төсвийн
тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны
төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн
2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн
даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай
хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр
өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг, санал,
дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./**

24-44

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
10 дугаар сарын 23-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 26 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Да.Цогтбаатар;

Чөлөөтэй: О.Алтангэрэл, Х.Баттулга, Ж.Баярмаа, М.Нарантуяа-Нара, У.Отгонбаяр;

Нэг.Хууль, тогтоолоор үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг, мөн газрын ахлах шинжээч Ш.Бумаажав, референт Д.Даваасамбуу, Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын дарга Б.Алтантуяа, мөн газрын референт Ч.Сарантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Тайланг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Х.Баасанжаргал, Д.Пүрэвдаваа, Д.Ганбат, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Уг асуудлыг 13 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, Улсын дээд шүүхийн ерөнхий нягтлан бодогч А.Эрдэнэцэцэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, мөн зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Наранбилэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Ч.Ариунтуяа, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, мөн албаны ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн Комиссын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Д.Ёндонжамц, ерөнхий нягтлан бодогч Ж.Баасанням, Улсын ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Нарийн бичгийн дарга Ч.Цасчихэр, мөн комиссын Ажлын албаны дарга Л.Очирсүрэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Гантулга, мөн газрын ахлах шинжээч Б.Хатантуул, Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга Ц.Ням-Очир, мөн газрын Стратеги, бодлого, инновац, хөгжлийн албаны дэд дарга бөгөөд Стратеги, бодлогын хэлтсийн дарга Г.Мөнгөншагай, Санхүү, ар талын албаны Санхүүгийн хэлтсийн дарга Н.Алтансүх, Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч Ж.Бямбасүрэн, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, ерөнхий нягтлан бодогч Ц.Чойжилсүрэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны дарга А.Намсаманд, мөн газрын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын дарга Т.Өнөртуяа, Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Энх-Од, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Давааням, мөн газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Энхнаран, Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга Ж.Буянбат, мөн газрын Санхүү, төлөвлөлт хангамжийн хэлтсийн дарга Т.Батцэцэг, Гадаадын иргэн, харьяатын газрын Захиргаа, удирдлагын газрын дарга И.Баатархүү, мөн газрын Санхүү, хангалт үйлчилгээний газрын дарга Ж.Солонго, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Б.Өлзийсайхан, мөн хүрээлэнгийн Захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах нягтлан бодогч Н.Уранчимэг, Архивын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэндсүрэн, мөн газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Лхамсүрэн, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн дарга П.Энхбаяр, мөн төвийн Захиргаа удирдлагын газрын Санхүү, ар талын тасгийн дарга Н.Уянгаа, Дотоод хэргийн их сургуулийн захирал О.Зоригт, мөн сургуулийн Санхүү төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Гантулга, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Н.Одонтуяа, мөн эмнэлгийн Штабын дарга бөгөөд инноваци хөгжлийн асуудал эрхэлсэн дэд захирал Г.Бат-Эрдэнэ,

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Санхүү, хангамжийн албаны дарга М.Мөнхбаяр, Хууль зүйн туслалцааны төвийн дарга Л.Уянга, мөн төвийн ахлах нягтлан бодогч Л.Болор-Эрдэнэ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын албаны дарга Л.Нямгэрэл, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэрсайхан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Төсвийн төслийг танилцуулгыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал танилцуулав.

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, С.Одонтуяа, Д.Ганбат, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд Н.Учрал, Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800633 төслийн кодтой, Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшгийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 170 тэрбум 899.7 сая төгрөг, 2026 онд санхүүжүүлэх дүн 25 тэрбум 635 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4 тэрбум 798 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Прокурорын газрын цахим хавтаст хэрэг, зөрчлийн системийн сервер, тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 4 тэрбум 798 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 4 тэрбум 798 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	11
Бүгд:	18

38.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804408 төслийн кодтой, Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7км. /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 216 тэрбум 979.6 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 40 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 12 тэрбум 631.3 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Дүүргийн шүүхийн нэгдсэн

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

барилга /Хан-Уул цогцолбор/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 75 тэрбум 254.5 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 28 тэрбум 666.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 12 тэрбум 631.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 10
Бүгд: 18
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2101101137 төслийн кодтой, Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг 546 тэрбум 556 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 121 тэрбум 721 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1 тэрбум 390 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны “Тарифт цалингийн жишиг шинэчлэн батлах тухай” 95 дугаар тушаал батлагдсантай холбогдуулан үүссэн зардлын зөрүү 1 тэрбум 111 сая төгрөг, Монгол Улсын дээд шүүхийн байр (Хангарди)-ны гадна фасадыг дулаалах, засварлах ажлыг гүйцэтгэх 279.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын урсгал зардлыг 300 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 300 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 9
Бүгд: 18
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 22 минут үргэлжилж, 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 48 минутад өндөрлөв.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
12 цаг 26 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.7 дугаар. 7.7.8 дахь 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Ирц 56 хувиар бүрдсэн байна. Ирцэд орсон гишүүд Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Хүрэлбаатарын Баасанжаргал, Энхбаярын Батшугар, Баярмагнайн Баярбаатар, Дашдондогийн Ганбат, Борхүүгийн Дэлгэрсайхан, Одсүрэнгийн Номинчимэг, Салдангийн Одонтуяа, Бөхчулууны Пүрэвдорж, Даваахүүгийн Пүрэвдаваа, Лхагвасүрэнгийн. Соронзонболд, Гончигдоржийн Уянгахишиг, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн гишүүдийн ирцтэйгээр ирц бүрэлдсэн байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаа танилцуулъя. Өнөөдөр 2 асуудал байгаа.

Хэлэлцэх асуудал нэгдүгээр асуудал Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан.

2.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд, Засгийн газар 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг явагдаж байна. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ бид нар.

Ингээд хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байвал санал юу? Нэрээ өгье.

Энэ дээр хэлэлцэх асуудал дээр тайлбар хэлэхгүй бол болохгүй байна. Сая Даргын дэргэдэх зөвлөл дээр Ерөнхийлөгчийн хоригийн асуудлыг хэлэлцэх асуудал дэмжигдсэн байгаа. Гэхдээ энэ Дэгийн хуулийнхаа дагуу үндсэн Байнгын хороогоороо эхлээд орох ёстой. Тэр нь Төрийн байгуулалтын байнгын хороогоор орно гэсэн үг. Тэгээд тэрний дараа хэлэлцсэний дараа манай дээр хэлэлцэгдэх учраас би сая яг түрүүн би тодруулж асууж байгаа энэ 2 асуудлаараа хэлэлцээд явъя. Төрийн байгуулалтын байнгын хороон дээр энэ асуудал хэлэлцэгдээд ороод

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ирвэл аягүй өнөөдөртөө бид нар эргээд хуралдах ийм шаардлага гарах байх шүү. Ингээд хэлэлцэх асуудлаа баталлаа.

Нэгдүгээр асуудалдаа оръё. Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлан.

Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайлангийн танилцуулгыг Засгийн газрын хяналтыг тэгвэл Эдийн засаг, хөгжлийн сайд Учрал сайд танилцуулах юм байна. Учрал сайдын микрофоныг өгье.

Микрофон өгөхөөс өмнө би хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Батцэцэг, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын ахлах шинжээч Ш.Бумаажав, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын референт Д.Даваасамбуу гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байна.

Энэ бол хууль, дараагийнх нь болохлоор Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын дарга Б.Алтантуяа, Улсын Их Хурлын Тамгын газрын Үнэлгээ, мониторингийн газрын референт Ч.Сарантуяа гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байна.

Ингээд Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Эрхэм Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 19.4-д заасныг үндэслэн Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх, дүгнэх журмын 3.7-д заасан аргачлалыг баримтлан Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоолын 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний тайланг танилцуулж байна.

Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим систем new.unelgee.gov.mn-д бүртгэлтэй хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 3839 заалтын хэрэгжилт дунджаар 58.8 хувьтай байна гэж дүгнэлээ. Тайлант оны эхний хагас жилийн хяналт шинжилгээний дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.2 хувиар буурсан нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журамд заасан аргачлалаар хэрэгжих шатад буюу 70 хувь, хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувь гэсэн ангилалд хамаарах заалтууд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журмын 3.7-д заасан үнэлгээний аргачлалаар хэрэгжээгүй ангилалд хамаардаг болсонтой холбоотой байна.

Хууль тогтоомж, тогтоолын шийдвэрийн нийт 9 төрлийн шийдвэрийг үндсэн 3 хэсэгт ангилан нэгтгэн дүгнэхэд Монгол Улсын 79 хуулийн 263, Их Хурлын 90 тогтоолын 491, Их Хурлын Байнгын хорооны 69 тогтоолын 290, нийт 238

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

шийдвэрийн 1044 заалтын хэрэгжилт улсын хэмжээнд дунджаар 42 хувийн хэрэгжилттэй байна.

Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим системд бүртгэж хяналтад авсан хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны шийдвэрийн хэрэгжилтийн дундаж өмнөх оны мөн үеэс 24.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Энэ нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журамд заасан аргачлалаар хэрэгжих шатад буюу 70 хувийн хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувь гэсэн ангилалд хамаарах заалтууд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан байгууллагын үйл ажиллагаа үр дүнг үнэлж дүгнэх журмын 3.7-д заасан үнэлгээний аргачлалаар хэрэгжээгүй ангилалд хамаардаг болсонтой мөн холбоотой.

Тайлант оны эхний хагаст ч хэрэгжээгүй 62 хуулийн 154 заалтын 85 заалт нь төрийн байгууллагуудын удирдлага, зохион байгуулалт хангалтгүйгээс шалтгаалсан гэж дүгнэгдэж байгаа тул цаашид Засгийн газраас хуулийн хэрэгжилтийг хангуулах, биелэлтийг хянах болон салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах, үйл ажиллагааны зохицуулалт, хэрэгжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх онцгой шаардлагатай байгааг харуулж байна.

Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилт, Засгийн газрын хяналт шинжилгээ үнэлгээний цахим системд бүртгэлтэй байгаа хууль, Их Хурлын тогтоол, Их Хурлын Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг тайлант оны эхний хагас жилийн байдлаар Шадар сайдын ажлын албад, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар болон төрийн захиргааны төв байгууллагад давхардсан тоогоор 1711 заалтыг авч үзэхэд 46 хувь буюу 780 нь хэрэгжсэн, 40 хувь нь буюу 676 нь хэрэгжээгүй, 15 хувь нь буюу 255 заалт хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй гэж дүгнэгдсэн байна.

Цахим системд бүртгэгдэж хяналтад авсан хууль, бусад шийдвэрийн холбогдох заалтын хэрэгжилт дунджаар 60.4 хувь байна. Хамгийн бага хувьтай нь Эрүүл мэндийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам байна.

Хуулийн хэрэгжилт.

Тайлан тооны эхний хагас жилийн байдлаар Шадар сайдын ажлын алба, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар болон төрийн захиргааны төв байгууллагын эрхлэх асуудлын хүрээний 70 хуулийн 389 заалтын хэрэгжилтийг авч үзэхэд дунджаар 42.8 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Үүнээс онцгой байдлын асуудал эрхэлсэн Шадар сайдын ажлын алба, Эрчим хүчний яам, Барилга, хот байгуулалтын яам, Батлан хамгаалахын яам хамгийн өндөр 78.6-100 хувь, Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам нь хамгийн бага буюу 7.7-26.7 хувьтай байна.

Хуулийн хэрэгжилтийг Их Хурлын Байнгын хороо тус бүрээр авч үзэхэд дунджаар 42.8 хувьтай байна. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

эрхлэх асуудлын хүрээний 3 хуулийн хэрэгжилт хамгийн өндөр буюу 80 хувь байгаа бол Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 9 хуулийн хэрэгжилт хамгийн бага буюу 20.6 хувь, үүнээс Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 12 хуулийн 27 заалтын хэрэгжилт 25.8 хувьтай байна.

Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд хууль, Их Хурлын болон Байнгын хорооны нийт 27 тогтоолын 236 заалт давхардсан бүртгэлтэй байгаагаас гадна 42.4 хувь буюу 100 нь хэрэгжсэн. 42.8 хувь буюу 101 нь хэрэгжээгүй. 14.8 хувь буюу 35 хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй гэж тус тус дүгнэгдлээ. Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилт 49.8 хувь байна.

Мөн тус хорооны эрхлэх асуудлын хүрээнд 12 хуулийн 32 заалтыг төрийн захиргааны төв 7 байгууллага тайлагнасан бөгөөд хэрэгжилт дунджаар 25.8 хувьтай. Үүнээс 25 хувь буюу 8 заалт хэрэгжсэн. 71.9 хувь буюу 23 заалт хэрэгжээгүй, 3.1 хувь буюу заалтыг хэрэгжүүлэх хугацаа болоогүй гэж тус тус дүгнэлээ. Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хуулийн хэрэгжилт хангалтгүй хэмээн дүгнэлээ.

Б.Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Тайлант оны эхний хагас жилийн байдлаар Их Хурлын дангаар гаргасан 78 шийдвэрийн тоогоор 670 заалтын хэрэгжилт Шадар сайдын ажлын алба болон Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, төрийн захиргааны төв байгууллагын 16 байгууллагад дунджаар 55.1 хувьтай байна. Үүнээс 43.4 хувь буюу 291 заалт хэрэгжсэн, 40.4 хувь буюу 271 заалт хэрэгжээгүй, 16.3 хувь буюу 109 заалтыг хэрэгжүүлэх хугацаа болоогүй гэж дүгнэгдсэн.

Дээрх Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг Байнгын хороо тус бүрээр авч үзэхэд дунджаар 55.2 хувьтай хэрэгжиж байна. Үүнээс нийт заалтын 45.2 буюу 337 нь хэрэгжсэн. 36.9 хувь буюу 275 нь хэрэгжээгүй, 17.9 хувь буюу 134 нь хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй гэж тус тус дүгнэгдлээ.

Улсын Их Хурал Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо хамтран 5 шийдвэр гаргасан байх бөгөөд хэрэгжилт дунджаар 92 хувьтай байна.

Харин Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Их Хурлын тогтоолын хэрэгжилт 56.2 хувь байна. Хууль зүйн байнгын хорооны тогтоолыг төрийн захиргааны төв байгууллагаар нь авч үзэхэд 12 шийдвэрийн давхардсан тоогоор 179 заалтыг Шадар сайдын ажлын алба болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар төрийн захиргааны төв байгууллагын 16 байгууллага дунджаар 55.5 хувьтай хэрэгжүүлсэн. Үүнээс 45.3 хувь буюу 819 заалт нь хэрэгжсэн, 36.3 хувь буюу 50, 65 заалт нь хэрэгжээгүй, 18.4 хувь буюу 33 заалтыг хэрэгжүүлэх хугацаа нь болоогүй гэж дүгнэгдсэн.

Их Хурлын Тамгын газрын хэрэгжилтүүдийг бусад Байнгын хороонуудтай харьцуулан дүгнэсэн. Их Хурлын Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт ямар байна вэ?

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Тайлант оны эхний хагас жилийн байдлаар Их Хурлын 7 Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд дангаараа 66 тогтоол, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороод хамтран 1 тогтоол гаргасан.

Дээрх нийт 67 тогтоолын 270 заалтын хэрэгжилтийг Байнгын хороо тус бүрээр авч үзэхэд 2 Байнгын хорооны хамтарсан тогтоол бүрэн хэрэгжсэн. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 10 шийдвэрийн 45 заалтын хэрэгжилт 76.9 хувьтай буюу хамгийн өндөр, Төрийн байгуулалтын байнгын хорооны 1 шийдвэрийн 10 заалт хамгийн бага буюу Их Хурлын Байнгын хорооны нийт хэрэгжилтээс доогуур 34 хувьтай байна.

Хууль зүйн байнгын хороо нь 45.8 хувь буюу дунджаас доогуур хэрэгжилттэй. Их Хурлын Байнгын хорооны 67 тогтоолын давхардсан тоогоор 544 заалтыг Шадар сайдын Ажлын алба болон Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, төрийн захиргааны төв байгууллагын 16 байгууллага дунджаар 56.4 хувьтай хэрэгжүүлсэн.

Үүнээс 48.5 хувь буюу 264 заалт хэрэгжсэн. 37.7 хувь нь 205 заалт хэрэгжээгүй, 75 заалт хэрэгжүүлэх хугацаа болоогүй. Тайлант оны эхний хагас жилийн байдлаар Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан 11-ийн тогтоолын 25 заалтын хэрэгжилт дунджаар 45.8 хувьтай байгаагаас 44 хувь буюу 11 заалт хэрэгжсэн. 52 хувь буюу 13 заалт хэрэгжээгүй, 4 хувь буюу 1 заалтыг хэрэгжүүлэх хугацаа болоогүй байна.

Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд бүртгэлтэй хууль, тогтоол, Байнгын хорооны тогтоол шийдвэрийн хэрэгжилт 46 хувьтай. Үүнээс Монгол Улсын 79 хуулийн 263 заалтын хэрэгжилт 36 хувьтай, Их Хурлын 90 тогтоолын 491 заалтын хэрэгжилт 48 хувьтай, Их Хурлын Байнгын хорооны 69 тогтоолын 290 заалтын хэрэгжилт 53 хувьтай тус тус дүгнэлээ.

Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системд Монгол Улсын хууль, Их Хурлын тогтоол болон Байнгын хорооны нийт 27 шийдвэрийн 236 заалт бүртгэлтэй байгаагаас 42.4 хувь буюу 100 нь хэрэгжсэн, 42.8 хувь нь 101 нь хэрэгжээгүй, 14.8 хувь буюу 35 нь хэрэгжилтийн хугацаа болоогүй.

Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилт 40.8 хувьтай гэж дүгнэж байна. Тайлант оны эхний хагас жилийн хяналт шинжилгээний үнэлгээний дүнг мөн оны өмнөх үетэй харьцуулахад 14.2 хувиар буурсан нь 2025 онд үнэлгээний аргачлал шинэчлэгдэж Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журамд заасан аргачлалаар хэрэгжих шатад 70 хувь, хэрэгжилт хангалтгүй 30 хувь гэсэн ангилалд хамаарах заалтууд 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан байгууллагын үйл ажиллагаа үр дүнг үнэлэх, дүгнэх журмын 3.7-д заасан хяналт шинжилгээний, үнэлгээний аргачлалаар хэрэгжээгүй ангилалд хамаардаг болсонтой холбож үзнэ.

Мөн хэрэгжээгүй зарим заалт нь хуулийн заалтыг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх боломжгүй байгаа бөгөөд захиргааны акт батлах үе шатны ажил болох хэрэгцээ шаардлагыг урьдчилан судлах төслийг боловсруулан үр нөлөөний

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

үнэлгээ, зардлын тооцоо хийх, холбогдох байгууллагуудаас санал авах, хэлэлцүүлэг хийх, бүрдүүлбэрийг хангах, батлах эрх бүхий этгээдэд өргөн мэдүүлэх зэрэг ажлууд хийгдэж байгаатай холбоотой хэмээн үзэж байна.

Их Хурлын Тамгын газарт үүнээс улбаалан уламжлах нь

Нэгд, Засгийн газарт үүрэг чиглэл болгосон Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг хариуцан тайлагнах байгууллагыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тогтоож, цахим системд бүртгэж, тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх.

2.Улсын хэмжээнд хяналтад авсан шийдвэрийн нэгдсэн бүртгэл хөтлөх, Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний new.unelgee.gov.mn-д систем, Их Хурлын Тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний систем хоорондын интеграци хийх нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах.

3.Засгийн газрын болон Их Хурлын Тамгын газрын цахим системд байгаа Монгол Улсын хууль, Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолд кодификац хийж бүрэн хэрэгжсэн, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан, шийдвэрт заасан хугацаа дууссан заалтуудыг хяналтаас хасах асуудлыг шийдвэрлэж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх саналыг уламжилж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Учрал сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгье.

Пүрэвдаваа гишүүнээр тасаллаа. Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Ерөнхийдөө сая хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь, хэмжээ бол маш доогуур сонсогдож байна л даа ерөнхийдөө дундаж хэмжээ нь. Эндээс яг хүснэгтлээд харахаар яг хуулийн ямар заалтууд яагаад хэрэгжээгүй байгаа вэ гэдэг нь ингээд тодорхой тайлбарууд нь явж байна. Тэгээд энэ хэчнээн жил дараалаад хэрэгжээгүй байгаа асуудлуудыг ер нь цаашдаа яах ёстой юм бэ? Жишээлбэл ингэж байгаа байхгүй юу би хамгийн амьдралд ойрхон жишээг л уншъя л даа. Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам, үзлэгийн хуудасны загвар, үзлэг явуулах эрх бүхий эмнэлгийн байгууллагын жагсаалт, тээврийн хэрэгсэл жолоодоход харшлах эм, бэлдмэл, тээврийн хэрэгсэлд байх эмийн сангийн иж бүрдлийн жагсаалт, зам, тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж байгаа юм. Тэгээд Энэ журам нь батлагдаагүй, хэрэгжээгүй, тус заалтын хэрэгжилтийг хангуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаагүй байна гэсэн байгаа. Энэ нь өөрөө Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай шинэчилсэн найруулга гээд 2015 оны 9 сарын 1 гэгчихсэн байгаа байхгүй юу.

Тэгэхээр яг иймэрхүү байдалтай маш олон заалтууд байна, журмууд батлагдаагүй байна, хэрэгжээгүй байна. Тэгэхээр энийгээ ер нь цаашдаа хэрэгжүүлэх тал дээрээ бид нар ямар арга хэмжээ авах ёстой юм бэ? Хэрвээ энэ

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

журам шаардлагагүй юм бол энийг хэрэгжүүлэх шаардлагагүй юм бол энийгээ тусад нь хасаад явах юм уу, яах юм гэдэг ийм асуудал байна даа? Ялангуяа энэ жолоочийн эрүүл мэндийн асуудал дээр бид нар анхаарал тавих ёстой. Яг энэ аваар, осол гараад байгаагийн цаана шалтгаан жишээлбэл эмийн хэрэглээтэй холбоотой байна уу, үгүй юү? Замын осол, аваар гарсан тохиолдолд эмнэлгийн үйлчилгээ яаж үзүүлэх юм, анхан шатны тусламжийг яаж үзүүлэх юм? Энэ тал дээр бол ялт ч байхгүй ажиллах ёстой юм. Бүүр ингээд хамгийн ойрхон сонсогдож байгаа юм жишээ л ингээд хэрэгжээгүй маш олон жил болчихсон байгаа байхгүй юу.

Тэгэхээр цааш цаашдаа ер нь энэ хэрэгжихгүй байгаа энэ 40 хэдэн хувь гэдэг хэрэгжилт бол яаж ч бодсон гүйцэтгэлийн хэрэгжилт ер нь 80 хувиас доош байна гэдэг чинь өөрөө маш асуудалтай. Тэгэхээр яам, тамгын газрууд дээр батлах ёстой журмуудаа батлахгүй байгаад байгаагийн шалтгааныг ер нь гэж тайлбарладаг юм? Энэ талаар бас тодруулга өгвөл яадаг юм.

Д.Цогтбаатар: Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Энэ Засгийн газрын энэ хяналт хэрэгжүүлэх ажил Их Хуралтайгаа уялдаж явах ёстой. Гэтэл энэ Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний энэ new.unelgee.gov.mn систем дээр төрийн захиргааны төв байгууллагууд болоод төрийн захиргааны байгууллагууд үнэлгээгээ яг тавьсан стандартын дагуу тайлангуудаа тавиад явдаг. Үүнийг ингээд үнэлдэг.

Гэтэл Их хурлын Тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний систем тусдаа. Тэгэхээр энэ Их Хурлын Тамгын газрын үнэлгээний систем, Засгийн газрын хяналтын энэ систем 2-ыг интеграци хийж нэгтгэх хэрэгтэй байгаа юм. Нэг ёсондоо Их Хурлаас баталсан шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг нь гүйцэтгэх засаглалд байдаг. Тэгээд хэрэгжүүлэхийг мэдээж Засгийн газар хариуцаж байгаа гэдэг утгаараа эргээд тайлангаа тавих гэхээр яг мэдээлэл, системүүд нь хоорондоо интеграци хийгдээгүй учраас хяналтын тайланг ийм Байнгын хороонд тавихдаа л бид нар ингээд нэгтгээд тавиад байгаа болохоос биш заавал энийг ийм механик байдлаар ингэж нэгтгээд байх уг нь шаардлага байхгүй. Бид бол тэгэхээр Их Хурлын Тамгын газрын системийг энэ Засгийн газрынхаа системтэй нэгтгээд, тэгээд үүнийг их өгөгдөл дээр боловсруулаад энэ тайланг зүгээр ингээд системээр нь гишүүдэд өгчихөд л болчих юм л даа хэрэгжилтүүдийг нь.

Тэгэхгүй болохоор тэгээд бид нар энд орж ирж тайлан уншаад л ингээд асуугаад ингээд яваад байгаа маш их цаг алддаг юм байна. Тийм учраас зүгээр систем дээр нь бид нар нэгтгэх ажлуудыг хийхээр ингээд төлөвлөж байгаа. Сая шинэ Засгийн газар байгуулагдсантай холбогдуулаад төлөвлөөд төсөвлөөд хянаж байгаа, мониторинг хийж байгаа эрх, үүрэг энэ Тэргүүн Шадар сайдын эрхлэх асуудалд ирсэн.

Тэгэхээр бид тайлангаа ч тавьдаг, эргээд хянадаг, үнэлгээгээ өгдөг, хариуцлагаа ч ярьдаг ийм эрх, үүрэг нэг газар ирснээрээ үр дүнд бас хүрэх бололцоо байгаа. Ийм учраас Их Хурлын Тамгын газрын интеграци хийх ажил дээр Их Хурлын Тамгын газрыг бол бас дэмжлэг үзүүлж ажиллаасай гэж бодож байгаа. Засгийн газрын болон Их хурлын Тамгын газрын ийм цахим системүүд хоорондоо интеграци хийж чадахгүй байгаа. Засгийн газрын цахим санд Засгийн газрын тогтоол, шийдвэрүүд, Ерөнхий сайдын захирамжууд, сайдын тушаал гээд

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

бүгдээрээ нэгтгэгдэж байгаа. Тэгээд очоод захиргааны актад Хууль зүйн яам бүртгээд авдаг. Тэгэхээр энэ ингээд цахим систем дээрээ нэгтгээд Их Хурлын Тамгын газрын энэ цахим сантай нь нийлээд бид нар энийг ингээд өгөгдөл болгоод боловсруулж чаддаг болчихвол, кодификац хийж бүрэн хэрэгжсэн ийм цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон зарим нэг энэ заалтуудыгаа шууд хасаад хасаад явахгүй бол тогтоол, шийдвэр, энэ захиргааны актуудын тоо бол ингээд өдөр ирэх тусам нэмэгдээд байдаг. Бид нар түүнийгээ хөөж чаддаггүй.

Тэгээд үнэлгээ хийх гэхээр яг үнэндээ ингээд дандаа ийм 40 хувьтай хэрэгжилт хангалтгүй гээд гараад байгаагийн шалтгаан бол зарим ийм хэрэгжих бололцоогүй маш олон ийм Байнгын хорооны тогтоолоор ч гэдэг юм уу, Тамгын газар ч гэдэг юм уу янз бүрийн ийм шийдвэр гаргачихсан. Тэгээд яг ингээд үнэлээд үзэхээр энэ чинь тэд тэддүгээр заалт хэрэгжээгүй гэхээр чинь хэрэгжилт 50 хувиа давна гэж бараг байхгүй байхгүй юу.

Тэгэхээр ач холбогдолгүй зүйлүүд дээр нь кодификац хийгээд ингээд зохион байгуулаад явах нь зөв байна. Тийм учраас бид ирэх жил ч ер нь ажлын даалгаврыг нь гаргаж байна. New.unelgee.gov.mn дээр Их Хурлын Тамгын газрын яриа энэ сандаа нэгтгээд интеграци хийчихнэ. Тэгээд Байнгын хорооны тогтоол, шийдвэр, бүх актуудыг нь тэнд нь нэгтгэчихнэ. Ингээд ирэх жилээс Байнгын хороон дээр ингээд их олон хуудас материал уншаад байхаасаа илүү зүгээр систем дээр нь харагдаад явдаг болж байгаа. Тэгээд энэ 5 жилийн үндсэн чиглэлийг ч гэсэн энэ жил шууд тоон хэмжүүртэй болгосон. Их Хуралд өргөн мэдүүлэх гэж байна. Тэгэхээр ирэх жил индикатортай учраас хэмжихэд их тодорхой болно гэдгийг хэлье.

Д.Цогтбаатар: Тодруулъя. Уянгахишиг гишүүний микрофон өгье. Нээрээ Ганбат гишүүнийг нэмээд оруулаарай. Энэ машин нь ажиллаагүй байна шүү. Уянгахишиг гишүүний микрофон.

Г.Уянгахишиг: Тэгэхээр ер нь тайлангийн нэгтгэл, интеграци хийх энэ тэр бол ерөнхийдөө технологийн асуудал болчихно. Гол нь тийшээ орж байгаа дата чинь бол яг хэвээрээ л байж таарна шүү дээ. Тэгэхээр яг тэр хэрэгжихгүй байгаа шалтгаануудыг саяын тайлбарласнаас миний ойлгохдоо нэгдүгээрт зайлшгүй батлах ёстой гээд байгаа ажил нь өөрөө хэрэгцээтэй ажил уу, хэрэгцээгүй ажил уу буюу кодификац талдаа анхаарах ёстой юм байна гэж ойлголоо.

Нөгөө талаасаа яамнуудын хувьд жишээлбэл одоо энэ ингээд хэрэгжээгүй гээд маш олон заалтууд байна шүү дээ. Тэгвэл энэ хэрэгжихгүй байгаа буюу ажлынхаа даалгавар буюу ажлын гүйцэтгэл дээр нь нөлөөлж орж байх ёстой үзүүлэлтүүд л харагдаад байна л даа. Тэгэхээр энэ нь яаж ажлын гүйцэтгэл дээр нөлөөлж ордог юм бэ?

Д.Цогтбаатар: Гүйцээгээд асуучих Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Тэгэхээр тэр шинээр хийх гээд байгаа системчлэл гэдэг юман дээр чинь тухайн сайдын гэдэг юм уу, агентлагийн даргын гэдэг юм уу ажлын гүйцэтгэл дээр шууд тооцоолох боломжтойгоор буюу хэрэгжүүлээгүй ажлууд нь ажлын гүйцэтгэлд нь Ки Пи Ай-д нь нөлөөлдөг байдлаар хийгдэх юм уу, эсвэл тэр зөвхөн тайлангаа л харахад ойлгомжтой байдлаар нэгтгэгдэх байдлаар хийгдэх гээд байна уу гэдэг бас тодруулга хэрэгтэй байна.

Д.Цогтбаатар: Хэддүгээр микрофонд 5? 5 дугаар микрофон өгье.

Б.Батцэцэг: Уянгахишиг гишүүний асуултад нэмэлт тайлбар өгье. 2025 оны 43 дугаар тогтоолоор анхны удаа үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Өмнө нь саяхан Учрал сайдын ярианд дурдсанчлан процесс дүгнээд яваад байдаг байсан болохоор болж байна гээд, зарим нь болчихсон гээд ингээд 100 хувиар хаагдчихсан асуудал байсан юм билээ. Энэ удаагийн хувьд бид нар үр дүнг нь үнэлж үзэхэд бас харьцангуй доогуур үнэлгээ гарч ирсэн. Засгийн газрын хуралдаан дээр хэлэлцэгдээд, энэ асуудал хэлэлцэгдээд Засгийн газрын хуралдаанаас болохоороо Хэрэг эрхлэх газраас энэ төсвийн ерөнхийлөн захирагч нар болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газруудад хэрэгжээгүй заалтынхаа шалтгаан, нөхцөлийг тайлбарлах, арилгах чиглэлийг 11 сарын 15-ны дотор ирүүл гэдэг үүрэг өгсөн. Энэ 43 дугаар тогтоолоор хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд бас шинэ ололттой тал гарч ирсэн нь бид нар газар дээр нь хяналт шинжилгээ, үнэлгээ хийх боломж бүрдсэн. Урьд нь зүгээр яамнуудаас ирсэн 30, 40, 30, 70, 100-г бид нар тэрүүгээр нь.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон гүйцээгээд хариулъя.

Б.Батцэцэг: Цаасан дээр бид нар тайланг үнэлээд яваад байдаг байсан бол болохгүй байгаа, эрсдэлтэй байгаа бүлэг зохицуулалтыг яаж хэрэгжиж байна гэдгийг ажил талбар дээр нь үнэлэх боломж бүрдсэн. Энэ 5 жилийн үндсэн чиглэл, хууль тогтоомжийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр гээд эд нар дээр Засгийн газраас хуралдаан дээр хэлэлцээд тэмдэглэл гаргахдаа зарим нэг асуудлаар бид нарыг газар дээр нь очиж үнэлгээ хийх чиглэлийг өгсөн байгаа. Тэгэхээр дараа дараагийн хэрэгжилтийн тайлангууд илүү их үр дүнд суурилсан агуулгаараа үнэлэгдэж орж ирнэ гэж бодож байна.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Асуулт. Өнгөрсөн жил бас бид нар ийм тайлан хэлэлцсэн. Яг ялгаа байхгүй л орж ирж байна. Тэгээд би бас яг сая миний өмнө асуусан Уянгахишиг гишүүнтэй адилхан нэг зүйл дээр илүү тодруулах гээд байгаа. Жишээ нь бид нар тарааж өгсөн энэ материалын Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын 16 дахь илтгэл гээд хүүхэд ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг мөрдөж ажиллах талаар гээд 2018 оны ийм тогтоол байгаа юм. Тэгээд энэ нь хэрэгжээгүй гээд 0, хэрэгжээгүй үгүй гээд ийм үзүүлэлттэй байгаа юм.

Тэгээд тайлбарыг нь харахаар 2025 оны эхний хагас жилийн тайлан ирүүлээгүй гээд. Бид нар ерөнхийдөө бол ялангуяа Засгийн газрын түвшинд би дандаа ийм идэвхгүй үйлдэлтэй буюу дандаа нэг талын үйлдэлтэй байна гэж хараад байгаа юм л даа. Тайлангаа ирүүлнэ, эсвэл журам батална, тэгээд орхино. Яг хүний амьдралд гарч байгаа өөрчлөлтөөр ерөөсөө ажлаа хэмжиж чадахгүй байгаад байна. Дээрээс нь тэр өөрчлөлтийг бид нар олж харж чадахгүй байгаад байна. Тэр өөрчлөлтийн төлөө ерөөсөө ажил маань өдөр тутмын ажил маань чиглэхгүй байна гэдэг ийм зүйл орж ирсэн цагаас хойш ялангуяа энэ Засгийн газар дээр гарч байгаа энэ үйл ажиллагаа, тайлангуудыг харахлаар ийм зүйл байгаад байна.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Тэгэхээр тайланг сайжруулах тал дээр сая интеграци хийнэ гэж ярилаа. Дараа жилээс бүүр илүү үр дүнд суурилсан аргачлалаар үнэлдэг болно гэж ярилаа. Цаашид манай бас Хууль зүйн байнгын хороо ч гэсэндээ яг энэ хэрэгжилтийг хангахдаа энэ тайлан юм уу, ямар нэгэн үйл ажиллагаа дээр суурилад ийм үйл ажиллагаа хийсэн юм байна тийм учраас хэрэгжсэн, эсвэл энэ журмыг баталсан юм байна тийм учраас хэрэгжсэн гэдэг ийм үзүүлэлтүүдийгээ болиод жишээ нь ялангуяа энэ хүүхдийн эрхийн асуудал дээр яг насанд хүрээгүй хүүхдүүд хөдөлмөр эрхэлж байгаа нь хэд юм, энэ жил энэ дүрэм, журмыг баталснаараа насанд хүрээгүй хөдөлмөр эрхэлж байгаа, ялангуяа хориглосон ажлын байран дээр хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн тоо хэрхэн буурсан юм бэ л гэдэг ийм үзүүлэлтийг олж хардаг баймаар байна. Тэгэхээр хойтон ийм үзүүлэлт орох уу дараа жил? Тэрнээс биш ийм журам баталсныг нь хэрэгжсэн гэдэг ийм тайлан бол би хойтонгоос, дараа жилээс авмааргүй байна. Тэгэхээр яг ийм тодорхой үр дүн дээр суурилсан шалгуур үзүүлэлт анхнаасаа энэ зүйлүүдээ өөрчилмөөр байна л гэдэг ийм саналтай байна. Тэгэхээр хойтонгийн ажлын үзүүлэлт өөр болж орж ирэх үү?

Д.Цогтбаатар: Дүн шинжилгээний тухай эхлээд Учрал сайд хариулчихъя. Дараа нь 8 дугаар микрофон бэлдэж байгаарай нэмэх юм байвал.

Н.Учрал: Тийм ирэх жилийн 5 жилийн үндсэн чиглэлийг боловсруулахад ер нь гишүүдийн ингээд тавиад байгаа энэ зарчмын энэ санал зөв л дөө. хэмжиж болохгүй ийм бага үзүүлэлттэй тэгээд 1 журам баталсныгаа ажилд тооцдог, арга хэмжээ зохион байгуулсныгаа ажилд тооцдог. Тэгээд нөгөөдөх нь хангалттай, хангалтгүй гээд ингээд үнэлэгдчихээр ямар ч үр дүн байхгүй байгаад байгаа юм. Тийм учраас энэ юутай холбоотой байна вэ гэхээр яг үзүүлэлтүүдээ хэмжигдэхүйц байдлаар тавьж чадаагүй.

Тэгэхээр бид нар ер нь цаашдаа энэ 5 жилийн үндсэн чиглэлийг энэ жил хийхдээ 14 индексийг тавьсан юм. Яг жишээ нь эдийн засгийн эрх чөлөөний индексээр 5 жилийн дотор дэлхийн орнуудаас эрэмбээрээ эхний 60-д орно. Ирэх жил 2 байр урагшилна. 2 байр урагшлахад аль яамнууд ямар ямар нэгж хувийн үүрэг гүйцэтгэх вэ гэдгийг л тавьж байгаа гэсэн үг. Тэгээд тэнд үр дүнд хүрээгүй л бол хангалтгүй гэж үнэлэхтэй адилхан. Энэ хөгжлийн бодлогын баримт бичгүүд бол өөрөө 5 жилийн үндсэн чиглэлийнхээ тэр индикаторууддаа нийцэх ёстой.

Жишээ нь эдийн засгийн өсөлтийг тооцоход эдийн засгийн өсөлт 5.7 хувьтай байхад алт, зэсийн агуулга нэмэгдэхэд 2.1 хувийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам хувь нэмрээ оруулахын тулд нэгд Оюу толгойн хэлэлцээр дуусах ёстой. Хоёрт Петрочайна-гийн хэлэлцээр дуусах ёстой ч гэдэг юм уу ингээд тавьчихаж. Тэгээд хэлэлцээр хийхийн тулд хэдэн форум хийх нь, хэдэн арга хэмжээ хийх нь сонин биш юм. Тийм учраас ирэх жил яг энэ Баасанжаргал гишүүний хөндөөд байгаа асуудлаар буюу ийм хэмжигдэхүйц байдлаар тавья гэж зорьсон. 5 жилийн үндсэн чиглэл 14 индекстэй 49 үзүүлэлттэй. Ингээд жилийн төлөвлөгөө бас яг ийм хэмжигдэхүйц байдлаар хэт их чанарын аргад суурилахгүй. Тэгээд quantitative арга зүйг л ашиглая. Тоогоороо л ярья. Тэгэхээр ирэх жилийнхийг ч гэсэн ингэж хийе гэдэг зорилгоор. Одоо бол яах вэ энэ чинь үзүүлэлт нь ийм байсан учраас Хяналт хэрэгжүүлэх газрыг буруутгаад ч гэдэг юм уу байхад аягүй хүндрэлтэй юм байна лээ. Үзүүлэлт нь ийм юм чинь ийм л юм гаргана хангалтгүй, хангалттай. Тэгээд хэрэгжихгүй болчихсон баахан заалтуудтай Их Хурлын Байнгын хорооны

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

тогтоолууд нь байгаад байдаг. Кодификац энэ тэр нь хийж чадаагүй. Тэгэхээр үүнийг хийхийн тулд энэ дээр хувийн хэвшил аягүй манлайлж ажилласан.

Жишээ нь тэр “Тус Солюшн” гээд компанийнхан бол өнгөрсөн хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиуд дээр хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа хуулиудыг эх өгөгдөл дээр кноп дарахад 5 минутад 5 минутад боловсруулж байна. Энэ хуулийн энэ заалт хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байна. Эдийн засгийн эрх чөлөөнд халтай ямар ямар хуулиуд, ямар ямар заалтууд байна гэдгийг их өгөгдөл дээр боловсруулж байна. Тэгээд тэр компанийнхантай бид нар хамтарч ажиллаад сая Эдийн засгийн эрх чөлөөний хууль дээр 200 хууль Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаагаас 200 хууль дээр байгаа заалтууд энэ эдийн засгийн эрх чөлөөг хаалттай байна гэдгийг шууд эх өгөгдөл дээрээ гаргаж ирсэнтэй адилхан Их Хурлын Тамгын газрын дээр байгаа цахим санд байгаа бүртгэлтэй бүх тогтоол, шийдвэрүүд, Засгийн газрын цахим санд байгаа тогтоол шийдвэрүүдийг интеграци хийчихье. Ингээд тэр хувийн хэвшилтэй хамтраад бол бид нар эх өгөгдөл дээр шууд боловсруулаад дүн гаргадаг болох ёстой.

Тэгээд ороод ирж байгаа Хууль зүйн байнгын хороон дээр ороод ирж байгаа хуулиуд үнэхээр хүний эрх, эрх чөлөө, тэр хүүхдийн эрхийг зөрчиж байгаа юм уу гэдгийг бид нар шууд л анализ хийдэг болох ёстой юм билээ. Тийм учраас ирэх жил бол ерөөсөө л тоогоор, тоон аргад суурилна.

Хоёрт, 5 жилийн чиглэлтэй нийцүүлнэ.

Гуравд, Бид нар энэ олон тогтоол, шийдвэр, захиргааны хэм хэмжээний актуудыг систем дээр үнэлдэг болно. Тэгээд түүний төлөө л ажиллана. Тэгэхээр Баасанжаргал гишүүний саналыг би бас бүрэн дүүрэн дэмжиж байна.

Д.Цогтбаатар: Сайд нь гүйцэт хариулчихсан учраас 8 дугаар микрофон энэ нэмж хариулах юм уу? Тийм, харин тийм Их Хурлын Тамгын газраас нэмж хариулах юм уу?

Пүрэвдаваа гишүүний микрофоныг өгье.

Д.Пүрэвдаваа: Энэ өдрийн мэндийг хүргэе. Бид нар чинь хууль гэдэг тоног төхөөрөмжөөр шийдвэр гэдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа улсууд гэж харж байгаа юм, ойлгож байгаа. Гэтэл өнөөдөр энэ шийдвэрийн хэрэгжилтийн талаар тайлан орж ирж байна л даа. Тэгээд энэ Улсын Их Хурлын тогтоол жишээгээр хэрэгжсэн нь 200 байхад хэрэгжээгүй нь 221, хугацаа хүлээж байгаа нь 70. Сая ажлын хэсгийн өгч байгаа тайлбараар энэ Их Хурлын тогтоол, хуульд кодификац хийх ёстой, цаг хугацаа болон энэ зарим макро түвшний нөлөөллөөс хамаараад хэрэгжихгүй заалтууд байна гээд тэгж байгаа юм.

Тэгээд би гайхаад байгаа юм энэ Үндсэн хуульд 30 дугаар зүйлд Засгийн газар нь улсын хууль, Улсын Их Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэгтэй гээд заачихсан. Үндсэн хуулийн 43 дугаар зүйлд Засгийн газрын шийдвэрийг бүх байгууллага, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй гээд заачихсан. Тэгээд эндээс юу харагдаж байна гэхээр зэрэг Засгийн газрын тогтоол 7 хоног бүр эргэн харах боломжтой. Заавал Улсын Их Хурлын ирц, Байнгын хорооны ирц, дээрээс нь Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу үе шатыг давах алба байхгүй. Засгийн

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

газар бол харьцангуй ийм түргэн эргэх маневртай шийдвэр гаргах боломжтой гэж байгаа юм.

Гэтэл хэрэгжиж байгаа 576 Засгийн газрын тогтоол байхад хэрэгжихгүй байгаа 189 гээд хагас жилийн хэмжээнд ингэж яригдаж байна. Тэгэхээр хариуцлага талдаа сахилгын, зөрчлийн, эрүүгийн гээд шийтгэлүүд байгаа шүү дээ. Та бүхэн маань сахилгын хэчнээн шийтгэл ноогдуулав, зөрчлийн хэчнээн шийтгэл ноогдуулав? Нэгэнт зөрчил байна гэдгээ тогтоочихсон байна шүү дээ. Хүндрүүлсэн нөхцөлөөр, давтсан, илэрхий эс үйлдэл гаргасан Эрүүгийн хуулийн заалттай хэчнээн тохиолдол байгаа юм? Тэгээд тодруулъя. Тодорхой хариулт авъя.

Д.Цогтбаатар: Учрал сайд хариулах уу? 5 дугаар микрофон.

Б.Батцэцэг: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Саяын энэ хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд Их Хурлаас батлагдсан хууль тогтоомж, шийдвэрүүд Их Хурлын Тамгын газар дээр хяналтад аваад Засгийн газар дээр үнэлгээнд орж явдаг. Тэгэхээр саяхан сайдын ярианд дурдагдсан ач холбогдлоо алдчихсан эсвэл хасах шаардлагатай заалтууд байгаад байна гэдэг маань одоо үндсэндээ 2000 оноос хойших хууль тогтоомж хяналтад явж байгаа байх тээ? Тэгэхээр Засгийн газар дээр давхардсан тоогоор 1374 орчим заалтыг хяналтаас хасъя гэдэг саналуудыг өгсөн. Гэхдээ энэ саналууд хасагдаагүй явж байгаа. Энэ таны асуултын 1 дүгээр хэсэг дээр. Бид Засгийн газар хяналт шинжилгээ, үнэлгээ гээд гэж үзээд байна гэхээр 1374 заалт нэг бол хэрэгжилт хангачихсан, нэг бол хэрэгжихэд шаардлагагүй, хяналтад байх шаардлагагүй болсон гэж үзээд байгаа юм. Тэгэхээр энэ заалтууд маань хяналтад яваад байхаар үнэлгээнд нөлөөлж байгаа асуудлууд бас байгаа.

Нөгөө талаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийх явцад хэчнээн албан тушаалтанд хариуцлага тооцов оо гэдэг нарийн тооцоо надад яг одоогоор алга байна. Зүгээр хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан орох болгонд үйл ажиллагаандаа учир дутагдалтай хандсан албан тушаалтанд хариуцлага тооцох асуудлуудыг холбогдох эрх бүхий албан тушаалтанд нь өгч байсан. Би энэний нэгдсэн тайланг танд албан журмаар гаргаад өгчихье Засгийн газрын төсвийн ерөнхийлөн захирагч нараас нэгтгэж аваад албан журмаар гаргаад өгье.

Д.Цогтбаатар: Тодруулъя. Пүрэвдаваа гишүүний микрофоныг.

Д.Пүрэвдаваа: Би чинь 1 минутаар 2 удаа тодруулж болно тээ? Тэгэхээр зэрэг эхний асуудал нь Үндсэн хуулиа яах юм бэ? Яг өнөөдрийн асуудал Үндсэн хууль зөрчсөн тохиолдол гарчхаад байна шүү дээ. Улсын Их Хурлаас батлагдсан хууль болон шийдвэрийг заавал биелүүлэх үүрэгтэй Засгийн газар. Тэгээд та бүхэн маань хэрэгжээгүй ээ бид зөрччихсөн гээд шийдвэрээ гаргачхаж. Энийг хууль зүйн хувьд хэн хариуцлага үүрэх юм бэ? Яг өнөөдөр энэ халуун сэдэв болчихоод байгаа юм.

Дараагийнх нь зүйл. Та бүхэн маань яагаад өнөөдөр хяналт шинжилгээ хийж байгаад хуучнаар Мэргэжлийн хяналтын газар шүү дээ. Миний ойлгож байгаагаар хяналт тавих ёстой. Тэгэхээр зэрэг сахилгын шийтгэл тийм үү? Дээрээс нь зөрчлийн шийтгэл хуультай байхгүй юу.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Д.Цогтбаатар: Яах вэ нэмж авах уу? 1 минутаа нэмээд авбал ав. Тэгвэл 5 дугаар микрофон.

Б.Батцэцэг: Гишүүн энэ салбарын хяналтын асуудал манайд хамаарахгүй. Тэгэхээр мэргэжлийн хяналтын хийдэг чиг үүрэг манай асуудал бас хяналт бас биш. Бид хийх вэ гэхээр санал, дүгнэлтээ танилцуулна Засгийн газар дээр, эс үгүй бол Ерөнхий сайдад, эс үгүй бол Эдийн засаг, хөгжлийн сайдад хуулиар олгосон чиг үүргийнхээ дагуу ийм 3 субъектэд үйл ажиллагаагаа танилцуулдаг. Манай үнэлгээ, хяналт шинжилгээний ажлууд дандаа Засгийн газрын хуралдаанаар танилцуулагдаад шийдвэр нь, эцсийн шийдвэрийг Засгийн газар дээр гаргадаг. Би түрүүн дутуу мэдээлэл өгсөн байна. Ер нь энэ хяналт шинжилгээ, үнэлгээний тайлангийн явцад үйл ажиллагаандаа хариуцлагагүй хандсан, чиг үүргээ хариуцлагагүй биелүүлсэн гэдгээр 3 яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засаг даргад хариуцлага тооцсон тохиолдол байдаг юм байна.

Д.Цогтбаатар: Тодруулах уу? Пүрэвдаваа гишүүн.

Д.Пүрэвдаваа: Та бүхэн маань ер нь хэр орчим хүний бүтцээр ажилладаг юм бэ? Засгийн газрын хуралдаан дээр мэдээллээ өгөхөөс гадна миний ойлгож байгаагаар та бүхэн маань ч бас дүгнэлт, дээрээс нь шийтгэл, торгууль тавих эрх нь байдаг гэж ойлгож байгаа шүү дээ. Улсын байцаагчийн ч гэдэг юм уу арга хэмжээ хариуцлага тооцох системийг та бүхэн эзэмшиж байгаа гэж харж байгаа. Үгүй байдаг юм уу? Тэгээд ямар байгууллага ер нь энэ хариуцлага тооцдог юм, одоогоор хэн хариуцлага тооцох ёстой юм өнөөдрийн хуулиараа? Та нар хариуцдаггүй юм бол хариуцдаг нь хэн юм?

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон.

Б.Батцэцэг: Гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэхдээ нэгдүгээрт хяналт шалгалт, хоёрдугаарт хяналт шинжилгээ, үнэлгээ, тандан судалгаа нь ийм иргэдийн өргөдөл, гомдлыг хянан шалгах гэсэн ийм үндсэн 4 чиг үүргийг хэрэгжүүлж байгаа. Бид манай бүтэц одоогоор Засгийн газар дээр 150 хүртэл хүний дээд орон тооны хязгаар маань батлагдсан. Бид нар 110 орчим хүнтэй ажиллаж байна. Үндсэн 4 чиг үүргийг хэрэгжүүлэхдээ хянан шалгагч нар маань хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Гэхдээ энэ нь улсын байцаагчийн эрхгүй. Бид гаргасан, илэрсэн зөрчил, дутагдал, алдааг Засгийн газар дээр танилцуулаад эцсийн шийдвэр нь Засгийн газар дээр тогтоол эсхүл тэмдэглэл хэлбэрээр гардаг. Бид хууль зөрчсөн үйлдэл тогтоох юм бол эрх бүхий албан тушаалтанд нь хуулийн дагуу арга хэмжээ аваад буцаж хариу мэдэгд гэдэг албан шаардлагыг хүргүүлдэг. Хэн эрх бүхий.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Сайн байцгаана уу? Энэ хяналт шинжилгээ ингээд тайлан тавиад хэр зэрэг үр дүнтэй байдаг юм бэ дээ? Гол нь юмны үр дүн биз дээ? Тэгээд энэ Улсын Их Хурлын хуулийнх нь биелэлт юм хум нь үүгээр ч их тааруу л гарсан л байна. 30, 40 хувьтай. Тэгээд энэ ард түмний амьдрал дээр ингээд яваад харахаар л болж бүтэж байгаа юм ерөөсөө алга л даа. Тэр ядууралтай гээд л 30 хувьтай л байсан 10 жил хэвээрээ л байж л байна гэх мэтчилний юмнууд байна. Их орон тоо, бүтэц юм хум нь байнга өөрчлөгдөх юм. Хяналт дүн шинжилгээний яам гэж байл

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

уу? Сайдтай нэг юм байсан санагдах юм. Тэгээд л одоо жоохон байж байгаад л ахиад л өөрчлөгдөх юм. Тэгээд мэргэжлийн хяналт гээд л байх юм. Энэ мэнээ ингэж байх нь хэнд хэрэгтэй байдаг юм бол оо? Та нарын байгаа юм чинь тэгээд өөрсдөө эмх цэгцгүй байж байж яаж энэ юмаа эмхэлж цэгцэлж дүн шинжилгээ гаргадаг юм бол? Ийм ийм үр дүнтэй ингэж явсан гэсэн та нарт тийм юм байна уу? Бид нар ингэж хянаад, шалгаад тэрний тайлангийн дагуу ингэж бид нар сайжрууллаа, жилээс жилд ийм байна гэсэн, цаашид ийм болно оо гэсэн ийм төлөвлөсөн барьсан юм байгаа юм уу тэрийг бас сонсчихмоор байх юм.

Нөгөө талаар бид нар ингээд яриад сууж байна. Гэтэл Хууль зүйн яамны сайд байгаа юм уу, байхгүй юм уу? Монгол улсын төсөв ярьж байдаг. Тэгээд Хууль зүйн сайдтай ч юм уу, Дотоод хэргийн сайдтай ч юм уу, үгүй ч юм уу. Энийгээ хэзээ эмхлэх юм бэ? Тэгээд Хууль зүйн байнгын хороо ингээд хараад суугаад байж болохгүй байх. Энэ асуудлыг энэ долоо хоногт нь шийдсэн нь дээр байх. Байгаа юм бол, байхгүй юм бол Засгийн газар энэ дээр ямар байдаг юм бэ? Бид нар энэ хий хоосон юманд ингээд л яриад суугаад байдаг ажил хариуцсан хүн нь байна уу, байхгүй юу? Тийм юм нь байхгүй бол бид нар мянга энэ дээр үр дүнгүй юм ингээд хий хоосон юм ярьж байх ямар шаардлагатай юм, хэн нь юугаа биелүүлдэггүй юм уу, яадаг юм ингээд тэрийгээ тодорхой болгомоор байна шүү дээ. Баахан сандал, суудлын хэрүүл хийсэн хүмүүс л тал тал тийшээ л гүйгээд байх юм. Энэ ард түмнээ бодож байгаа, тэр тангаргаа биелүүлж байгаа ийм төрийн албан хаагч, ийм Улсын Их Хурлын гишүүд ер нь цөөрөөд байгаа юм биш үү айн? Энэ дотор тэгээд л болж байгаа, бүтэж байгаа юм шиг. Нөгөө тэмээн хярвал өөрийнхөө толгойг элсэн дотор хийчхээд л би нуугдчихсан гэж бодоод байдаг шиг иймэрхүү маягтай энэ улс орны ажлыг явуулж болохгүй гэж үзэж байна.

Тэгээд хаа хаанаа хариуцлагатай баймаар байна. Жоохон ажил хэрэгч баймаар байна. Засгийн газар өчигдрөөс хойш, өчигдөр шөнөөс хойш хэвийн Засгийн газар боллоо гэж ойлгоод байгаа. Хууль зүйн сайд чинь хааччихсан юм бэ? Тэрийгээ хэзээ тавих юм бэ? Тэр гэмт хэрэгтэйгээ хэзээ тэмцэх юм бэ? Та нар гэмт хэрэгтэйгээ тэмцэхгүйгээс л ийм юм болж байна шүү дээ.

Д.Цогтбаатар: Шадар сайдад микрофон өгье. Учрал сайдын микрофоныг.

Н.Учрал: Тийм Засгийн газар бол үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа. Төсвөө цаг хугацаандаа мэдүүлсэн. 5 жилийн үндсэн чиглэлийг 10 сарын 15-ны өдөр Засгийн газарт танилцуулж Их Хуралд өргөн мэдүүлэхээр тов хүссэн бичгээ явуулсан. Төсөв бас хуулийнхаа хугацаанд явж байна. Төсөв дээр ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байна гэж бид нар ойлгож байгаа. Засгийн газрын зүгээс төсвийн ажлын хэсэгт манай Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам мэргэжил, арга зүйн туслалцаагаа үзүүлээд хамтраад ингээд ажиллаж байгаа.

Ер нь энэ тогтолцооны хувьд эргэж харахгүй бол болохоо больсон. Өмнө нь тэр хяналтын яам гэж байгаагүй. Хяналтын үндэсний хороо гээд энэ агентлаг дор нь ажиллаж байсан. Тэгээд одоо та бүхний Засгийн газрын энэ хяналт хэрэгжүүлэх газар та бүхний мэдэх Мэргэжлийн хяналтын газар биш. Энэ Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх хуультай. Нэг ёсондоо хуучин бол дотоод хяналтаа хариуцаж байна л гэсэн үг. Дотоод хяналттаа. Нөгөө мэргэжлийн хяналтын чиг үүргүүд салбарын яамнууд руу тухайн үед шилжсэн юм байна лээ. Одоо хуультай. Яам болгон дээр салбарын хяналтын газар ажилладаг байцаагчийн эрхтэй. Энэ Хяналт хэрэгжүүлэх газарт байцаагчийн эрх байхгүй. Тэр байцаагч нар гээд яам болгон

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

дээр байгаа нөхдүүд хуучин Мэргэжлийн хяналт дээр салбараа хариуцаж байсан хүмүүс зарим яаман дээр 3 хүн, зарим яаман дээр 10 хүн гэнэт яаман дээр нь очоод бид нар ирлээ гээд очоод суучихсан. Тэгээд тэрийг сайд нь ч хариуцдаг үгүй нь үл мэдэгдэх тэгээд Хяналт хэрэгжүүлэх газар тэднийг удирдаж чадахгүй. Байцаагчийн эрхтэй ийм хүмүүс байгаа. Уг нь хяналт шалгалт давхардлыг арилгая гэдэг зорилгоор энийг хийгдсэн ажил. Гэтэл одоо энэ ажил бүүр хяналт бүүр их хүнд сурталтай боллоо гэдгийг бизнесийн байгууллагууд хэлээд байгаа юм.

Яагаад гэхээр энэ яамнаас шалгалт ирлээ гээд нөхөр ирэх юм. Энийг нийслэлээс дахиад ирэх юм. Энэ агентлагаас бас юм ирэх юм бол энэ олон шалгалтаа болиоч л гээд байгаа юм. Ер нь бид нар энэ хяналт хэрэгжүүлэх асуудлыг нэг мөр цэгцлээд дахиад хууль, дүрэмдээ өөрчлөлт оруулах шаардлагатай гээд бас ажиллаж байна. Одоо эдний чиг үүргийг ч гэсэн их ойлгомжтой болгохгүй бол хяналт багадаагүй л дээ. Тэгэхдээ яг ард түмний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангуулах чиглэлээр ажиллах, ялангуяа хүнс, хөдөө аж ахуйн салбарт жишээ нь хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэнд гээд хэдэн чиглэл бол хяналтынх нь чиг үүрэг нь хэрэгжээд л ингээд л явж байгаа шүү дээ. Тэгэхээр энийг бол нэлээн цогцоор нь харахгүй бол болохоо больсон шүү. Тэгээд энийг бас гишүүд маань их олон талаас нь харж энэ Өргөдлийн байнгын хороо байгуулагдсан байна лээ.

Тэгээд энэ дээр бас ялангуяа энэ Хөдөлмөрийн аюулгүй байдал чиглэлээр, хүнсний аюулгүй байдал чиглэлээр их анхаарахгүй бол ер нь жоохон эзэнгүйдэх шинж рүү л орлоо доо л гэж ингэж дүгнэх ёстой. Тэгээд Хууль зүй, дотоод хэргийн сайдыг томилуулах саналаа Ерөнхий сайд Үндсэн хуулиар заагдсан бүрэн эрхийнхээ дагуу танилцуулгаар өргөн мэдүүлсэн. Тэгээд сүүлдээ ч тэгээд юу ч болов, одоо жонхуурна гэдэг л болж байна даа. Хууль зүйн сайдыг томилж энэ ажил үүрэгт нь оролцуулахгүй бол хэн хариуцах вэ гэдэг их ойлгомжгүй байгаа. Ерөнхий сайдын танилцуулах бичиг хүргэгдчихсэн байгаа. Тэгээд чуулганд танилцуулбал Хууль зүй, дотоод хэргийн сайд ажилдаа орох байх. Түүний дараа Хууль зүйн байнгын хороо бас шинэ Хууль зүйн сайддаа бас энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийн асуудлаар илүү цаг гаргаж ажиллах шаардлага үүснэ. Тийм учраас хуулийнхаа хугацаанд Засгийн газар ажлаа явуулж байгаа гэдгийг хэлье.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье тодруулъя.

Д.Ганбат: Одоо чинь тэгээд л гадаа бензин тасраад л, гэрэл, тог нь тасраад л, дулаан нь хүндрээд л энэ агаар, түлш нь байхгүй болоод л энэ тэр байна гэх юм. Энэ асуудал та нарт хамаатай юм уу, хамаагүй юм уу? Тэгээд энэ хууль, шийдвэрийн хэрэгжилтийг та нар өөрсдөө хангалтгүй гэж дүгнэсэн байна л даа. Ер нь ч хангалтгүй байна л даа. Тэгээд энийг яаж хангалттай болгох юм бэ? Энэ Улсын Их Хурлаас гаргаад байгаа шийдвэр, хууль нь болохгүй байна уу, эсвэл өөр юундаа байна? Эсвэл та нарын тэр бүтэц юм хумандаа байна уу? Тэгээд багш нар нь цалингүй, цалин нь хангалтгүй, хүүхдүүд нь танхим сургууль нь багталцахгүй, боловсролоо авах хэмжээндээ авч чадахгүй ийм л байдалтай байгаад байна. Тийм тэгээд хамаг сүүлийн 10-аад жил бүх байраар л ухарч байна шүү дээ. Ухарч байна шүү дээ.

Д.Цогтбаатар: Гүйцээж авах уу? Учрал гишүүн хариулах уу, эс үгүй бол 5 дугаар микрофон.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Б.Батцэцэг: Ганбат гишүүний асуултад хариулъя. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээд явж байхад хэд хэдэн бас бид нар бас хэрэгжилтийг илүү бодитой болгох талаар саналууд бас Засгийн газрын хуралдаан дээр танилцуулагдсан. Үүний нэг нь яах аргагүй Засгийн газрын байгууллагуудын дотоод үйл ажиллагааны хоорондын зохион байгуулалтын асуудал, үйл ажиллагааны уялдааны асуудал. 43 дугаар тогтоолын хүрээнд бид нар яагаад хэрэгжээгүй их гараад байна вэ гэхээр процессыг бид нар хэрэгжүүлээд явж байгаа процессыг хэрэгжилт гэж үзэхгүйгээр шууд нойллолж байгаа дээр бас хэрэгжилтийн үнэлгээ бага гараад байгаа. Түрүүн сайдын танилцуулгад дурдсан.

Нөгөөтээгүүр бас бид нар харах юм байна. Тэр маань юу гэхээр аливаа тогтоол, шийдвэр гарахдаа хугацаа бас тавихгүй байна. Өөрөөр хэлбэл үнэлэхэд бодитой биш агуулгаар бас гараад байгаа нь үнэлгээ дээр хүндрэл уч.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Тодруулах уу? 5 дугаар микрофон.

Б.Батцэцэг: Тэгэхээр үр дүнг нь харах хугацаа тодорхой биш байдгаас, зарим тохиолдолд хугацаа тавих шаардлагатай зохицуулалтууд дээр хугацаа байхгүй байдгаас бас үнэлгээ дээр асуудал гарч байгаа юм байна. Зарим тохиолдолд яг бид нар хууль тогтоомжийн хэрэгжилт ярьж байгаа учраас хууль тогтоомжтой холбоод ярихад зарим шийдвэрүүд давхардсан шинжтэй. Хууль дээр ч бас тийм асуудлууд байна. Бид нарын дэлгэрэнгүй тайлан дээр бас энэ явсан байгаа. Аль аль хууль дээр давхцал үүсээд байгаа юм бэ, аль аль хууль дээр хэд гарчхаад байгаа юм бэ, зарим Байнгын хорооны шийдвэрүүд нь хуулийнхаа зохицуулалтыг яг давтаад гарчихсан байх жишээтэй ийм тохиолдлууд бас байгаад байгаа.

Д.Цогтбаатар: Би 1 асуулт асууна аа. Учрал сайдаас асуух асуулт байна. Түрүүн өөрийн чинь би хариултаас нэг юм ойлголоо. Ер нь энэ ажлын, хуулийн хэрэгжилт, хууль, журмын хэрэгжилтийн талаарх шалгуур үзүүлэлтүүдээ илүү тоон хэлбэрт шилжүүлж, илүү нарийвчилж ийм хэрэгжсэн, хэрэгжээгүй гэх мэтийн их бүдүүн баараг байдлаас илүү нарийвчилсан индикатор руу шилжих гэж байгаа юм байна, ийм систем рүү шилжих гэж байгаа юм байна гэж өөрийг чинь түрүүн асуултад хариулж тайлбарлаж байна гэж ойлгож болох уу? Энэ чинь тэгэхлээр Байнгын хорооны хуралдаан дээр ийм юм ярина гэдэг чинь Засгийн газар өөрөө үүрэг авч байна гэсэн үг шүү дээ. Өөрөө өөрийнхөө өмнө бид нар ийм юм боловсруулж оруулж ирнэ гэж би тэгж ойлголоо. Энэ зөв үү?

Микрофонд. Учрал сайдын микрофон.

Н.Учрал: Ер нь төлөвлөөд, төсөвлөөд, хянаад мониторинг хийх чиг үүрэг Тэргүүн Шадар сайдын эрхлэх асуудалд ирсэн. Тэгэхээр хөгжлийн бодлогын баримт бичгүүдээ боловсруулж байгаа чиг үүрэг бол над дээр байгаа. Тэгэхээр боловсруулж байгаа бичиг баримтуудаа эргээд үнэлэх чиг үүрэг байгаа учраас үнэлэхийн тулд илүү тоон арга руу шилжих, хэмжигдэхүйц болгох шаардлага байгаа учраас 5 жилийн чиглэл дээр ч тэр бид нар 14-ийн энд индексийг үндэсний үзүүлэлт гээд, салбарын үзүүлэлт нь 49 гээд. Тэгээд төсвийн ерөнхийлөн захирагч нарын үзүүлэлт гэж ангилсан. Яг үүндээ нийцүүлсэн жилийн төлөвлөгөөг ирэх жил боловсруулах ёстой. Тэр нь дандаа хэмжигдэхүйц байна. Түүнтэй адилхан

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хөгжлийн бодлогын баримт бичгүүд, хууль тогтоомжийн шийдвэрийн биелэлтүүд өөрөө хэмжигдэхүйц байх байдлаар үзүүлэлтүүдийг нь өөрчилж чадвал ирэх жил ийм 49 хувийн хангалттай байна, хангалтгүй байна. Журам гаргасныг нь ажил хийсэнд тооцоод ч юм уу, арга хэмжээ хийснийг нь, хэлэлцүүлэг хийснийг нь ажил хийсэнд тооцоод юм уу ийм байдлаар үнэлж авах нь бол багасна.

Тэгээд Их Хурлын Тамгын газрын цахим сан, Хэрэг эрхлэх дээр байгаа, Засгийн газар дээр байгаа цахим сан хоёрыг нэгтгэнэ. Тэгээд энэ хууль тогтоомж, шийдвэрүүд, захиргааны хэм хэмжээний актуудыг бол бид нар системийн хувьд интеграци хийнэ. Яг одоо хууль тогтоомж дээр хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн дээр, эх өгөгдөл дээр анализ хийж болж байгаатай адилхан хууль тогтоомжийн шийдвэрийн биелэлтүүдийг тэр эх өгөгдөл дээр анализ хийдэг ийм байдал руу шилжүүлнэ.

Тэгэхгүй бол ингээд жил болгон ийм үзүүлэлт нь тодорхойгүй хэт их ерөнхий учраас ийм хангалттай, хангалтгүй ийм шударга бус байдлаар үнэлэгдээд байгаа. Энэ асуудлыг Байнгын хорооны даргын яг сая хэлсний дагуу бид нар хийж хэрэгжүүлнэ.

Д.Цогтбаатар: Би тэгэхлээр энийг ингээд үүрэг авлаа гэж хүлээж авч ойлголоо шүү. Манай Байнгын хорооныхон энийгээ бас тэмдэглээд аваарай. Дараагийн удаа ч гэсэн манайхан асуухдаа ийм юм ярьж байсан шүү гээд гишүүд асуух ийм үндэслэл бүрдэж байна шүү дээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Учрал гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Харин тийм бас Цогтбаатар даргын хэлж байгаа тэр шинэлэг гэх юм уу ер нь бид хэд ийм явж ирсэн юмнууд дээрээ зөв болгохгүй бие биеэ хуураад байгаа юм. Тэгээд би энэ ажил хийж байгаа залуучуудыг буруутгамааргүй байна. Хууль дээр ер нь хяналт шинжилгээ хийнэ гэж ойлголт байдаггүй юм. Хууль чинь байнгын өдөр тутам тэр хуулийн заалт өдөр хэд ч хэрэглэгдэж, хэрэгжиж болдог байхгүй юу. Тэгэхээр энэ хар даа Засгийн газрын энэ оруулж ирж байгаа хяналт шинжилгээний дүгнэлт чинь бүүр буруу болчихоод байгаа байхгүй юу. Үүнээс хуулийн 263 заалтын хэрэгжилт 36 байна гэдэг чинь Засгийн газар ерөөсөө хууль биелүүлэхгүй байгаа гэдгээ тайлагначхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр ингэж тайлагнаж болохгүй. Тэгэхээр бид хэд энийгээ өөрчилмөөр байгаа.

Тэгэхээр энэ хэлж байна гэхээр хяналтад байгаа заалт нь зөвлөл хороо байгуулах ч байдаг юм уу, журам гаргахыг хэрэгжихсэн, хэрэгжээгүй гээд байх шиг байгаа юм. Уг нь тэр биш юм байгаа юм. Тэгэхээр энэ хуулийн хэрэгжилтийн явцад Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа, эсвэл тэр хөдөлмөрлөх эрх, тэр хүүхдүүдийн эрх, гэмт хэрэг хэдэн хувиар буурав ч гэдэг юм уу, эдийн засаг хэдэн хувиар өсдөг тэр хуулийн үр нөлөө байдаг байхгүй юу. Үр нөлөө. Тэр хуулийг хэрэгжилтийг дор хаяж тогтмол хянаж үр нөлөөг л танилцуулах ёстой. Энэ Монголд ийм төсвийн дарамт авчраад байна. Хүний эрхийг ингэж дээрдүүлсэн боловч бас ийм төсвийн дарамт байна. Энэ хүний эрх дээрдэж байгаа боловч

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

төсөв, санхүү нь хүрэлцэхгүй байна. Зохион байгуулалтын хувьд ерөөсөө буруу ажилласан учраас энэ хууль хэрэгжээгүй байна гэдэг зүйл танилцуулах чиглэлдээ хандаач. Тэрнээс биш өнөөдөр Засгийн газар Монгол Улсын Үндсэн хуулиар заасны дагуу хууль хэрэгжүүлэх үүрэгтэйг чинь 36 хувь биелүүлж байгаа гэдэг чинь буруу байхгүй юу. Энэ тэгээд буруу мессеж өгчихнө. Тэгэхээр энийгээ хэдүүлээ ингэж хийж болохгүй л гэсэн үг.

Тэгэхээр уг нь бусад оронд Ерөнхий сайдын дэргэд хууль тогтоомжийн агентлаг юм уу, эсвэл бие даасан тийм lorry ... commission гэж байдаг. Энэ хуулийн үр нөлөөг судлаад ийм эерэг, сөрөг үр дагавар авчирч байна. Энийг ингэмээр байна гээд хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулах уу, шинэчлэх үү яах вэ гэдэг юмаа шийддэг байхгүй юу. Хяналт шинжилгээ хийдэггүй юм хууль дээр. Анхнаасаа бид хэд ингээд буруу явсаар байгаад сүүлдээ хяналт шинжилгээ гэдэг чинь өдөр тутмын процесс шүү дээ. Тэгэхээр хуулийг өдөр тутам хэмжинэ гэж байхгүй.

Тийм учраас тодорхой цаг хугацаанаас нь хүчингүй болох хүртэл нь хуулийн хэрэгжилтийн хувийн хэрэг гэж юм байдаг. Энд тэчнээн төсөв зарцууллаа, тэчнээн журам гарсан байна, журмууд нь тэгж өөрчлөгдсөн байна, хуулийн хэрэгжилт дээр Цэц дээр ийм шийдвэр гарсан байна, хуулийн хэрэглээний явцад шүүхийн маргаан тэгж өссөн байна, нэмэгдсэн байна, ийм ийм эерэг үзүүлэлтүүд авчирсан байна, ийм ийм сөрөг үзүүлэлт яасан байна, энийг ингэмээр байна гэдэг дүгнэлтийг бие даасан ийм мэргэжлийн судлаачид гаргадаг юм. Тэрнээс биш хянан шалгагч нар биш. Тэгэхээр уг нь энэ загвар руу л бид нар ингээд ормоор байгаа юм. Тэгээд би яах вэ зүгээр энэ асуудлыг Учрал сайдад уг нь Хэрэг эрхлэх газрын дарга байж байхад ярилцаж байсан сэдэв.

Хоёрдугаарт ийм юм байдаг гишүүддээ бас би анхаараад бид хэд нэхэх ёстой юм. Учрал сайдын тэр хоёр системийг нэгтгээд нэг явна гэдэг зөв байх. Кодификац хийж болохгүй. Улсын Их Хурал техникийн алдаатай баахан хуулиуд баталчихсан байдаг юм. Энийг үе үе Ерөнхий нарийн бичгийн дарга нар ч, би Хууль зүйн яаманд байсан учраас мэдээд байгаа юм. Яаж янзлах вэ гэхээр ямар ч хариулт байхгүй. Одоо Улсын дээд шүүхээс лавлагаа авъя ч юм уу, тодорхой хуулийн лавлагаа өгөөд энийг маргааныг шийдье гэхээр нэмэлт, өөрчлөлтийг нь кодификац хийж эх бичвэрт нь оруулах бололцоогүй батлагдчихсан тийм олон хуулиуд байдаг байхгүй юу. Үндсэндээ үе үеийн манай Улсын Их Хурлын алдаа гэсэн үг. Тэгээд энийгээ бид хэд дотроо ярьж чаддаггүй, шийдэж чаддаггүй. Тэгээд ийм ингээд зөрүүтэй юмнууд байдаг. Ялангуяа төсөв дагасан хуулиуд маш их алдаатай техникийн хувьд батлагдчихдаг. Яг бодит амьдрал дээр кодификац хийж болдоггүй аль хуулийг нь өгөхөө мэдэхээ байчихдаг ийм лавлагаа дээр юмнууд зөндөө байдаг.

Тэгэхээр энийг Учрал сайд ярих нь зөв юм болов уу, үгүй юу нэг системтэйгээр залруулга хийх 1 удаагийн ажлыг хиймээр байгаа юм Батцэцэг ээ, Энийг Хууль зүйн яаман дээр мэдээллүүд нь байх ёстой. Улсын Их Хурлын Тамгын газар дээр ч байх ёстой. Тэгэхээр энийг хийхгүй бол сүүлд нь энэ дээр нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа техникийн алдаа гарчихсан юм. Хоёуланг нь өгөх гэлтэй ч биш ийм сонин сонин юмнууд бас байдаг юм шүү. Ер нь цаашдаа энэ арга барилаа өөрчлөхгүй бол ингэж бие биеэ хуурч болохгүй. Тэгээд хэрэгцээ хэрэгжээгүй гэдэг чинь аймаар утгагүй болчихоод байгаа байхгүй юу.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Д.Цогтбаатар: Учрал гишүүний микрофоныг өгье. Окэй тэгвэл ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Хууль, тогтоолоор үүрэг чиглэл болгосон Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн тайланг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

13.27 цаг

Хоёр дахь асуудал төсвийн асуудал байгаа. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд.

Засгийн газар 2025 оны 9 сарын 1-нд өргөн мэдүүлсэн байгаа. Гурав дахь хэлэлцүүлэг явуулж эхлэх гэж байна.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан. Сангийн сайд байгаа юу? Учрал сайд унших юм байна. Танилцуулгыг Монгол Улсын Шадар сайд Учрал уншиж танилцуулна. Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулж, 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Ирэх 2026 оны төсвийн төслийг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөтэй уялдуулан боловсрууллаа.

Төсвийн төсөлд туссан тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах онцлог арга хэмжээнүүдийг дурдъя.

Нэгдүгээрт, төсвийн урсгал зардлын хувьд

Удирдах албан тушаалтны орон тоог бууруулж, төрийн албан хаагчдын нийт орон тооны тэлэлтийг хязгаарлахын зэрэгцээ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төсвийн байгууллагын үр ашиггүй зардлыг бууруулж, хэмнэгдсэн хөрөнгийг нийгмийн салбарт зарцуулахаар, Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр батлагдаж, нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх, Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны дагнасан шүүхийг шинээр байгуулахаар заасантай холбогдуулж, 2026 оны төсвийн төсөлд үйл ажиллагааг хагас жилээс эхлэн хэрэгжүүлэхээр тооцож, холбогдох орон тоо 9.5 тэрбум төгрөгийн зардлыг санхүүжүүлэхээр, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.1-д Эрүүгийн хуульд заасны дагуу оногдуулсан торгох ял, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 40 хувиас доошгүй хувийг дараагийн жилд төсөвт тусгаж санхүүжүүлэхээр заалаа.

Судалгаа, шинжилгээ, шинжлэх ухаан, техник технологийн орчин үеийн ололтод үндэслэж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг үр өгөөжтэйгөөр зарцуулсны үр дүнд нийгмийн хэв журам сайжирч, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улмаар гэмт хэрэг, зөрчлийн тоо хэмжээ буурах, иргэдийн амар тайван амьдрах орчин бүрдэх ач холбогдолтой юм.

Энэ хүрээнд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар төсөвт төвлөрөх торгуулийн орлогын 40 хувийг 2026 оны төсвийн төслийн орон нутгийн суурь зарлагад өмнөх оноос 44 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 59.8 тэрбум төгрөгт хүргэхээр, санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага ФАТФ-аас 2027-2029 онд хийх харилцан үнэлгээнд бэлтгэх хүрээнд Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны хэрэгжилт, үр дүнтэй байдлыг сайжруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын үр дүнг нэмэгдүүлэх, шинэ технологийн хэрэглээнээс үүдэх эрсдэлийг бууруулах бодлого боловсруулж, олон улсын туршлага, техник хэрэгсэл, программ хангамжийг судлан нэвтрүүлэх, гэмт хэрэг илрүүлэх арга барилыг шинэ түвшинд хүргэх зэрэг ажлууд багтаж байна.

Мөн Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэг болон ФАТФ-ын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор тусгай чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг тус тус 2026 оны улсын төсвийн төсөлд тусгалаа.

Хоёрдугаарт, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хуульд заасны дагуу 2025 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн иргэдээс санал авч, сум, дүүрэг, аймаг, нийслэл, салбар яамны түвшинд үе шаттайгаар төлөвлөлөө. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр нийт 14.4 их наяд төгрөгийн санхүүжих дүн бүхий 1712 төслийн санал хүлээн авснаас холбогдох шалгуур үзүүлэлт, зарчим, бодлогыг харгалзан эрэмбэлж, 579 төсөл, арга хэмжээнд 3 их наяд 267.3 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгалаа.

Нийт хөрөнгө оруулалтын 67 хувь буюу 2 их наяд 101, 81.9 тэрбум төгрөг нь үргэлжлэн хэрэгжих бол 33 хувь буюу 1 их наяд 85.5 тэрбум төгрөг нь шинээр хэрэгжих хөрөнгө оруулалт байна. Энэ нь 2022-2023 онд батлагдсан төслийн тоотой харьцуулахад 2 дахин буурсан үзүүлэлт бөгөөд төслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, үнэлэх, эрэмбэлэх шалгуур үзүүлэлтийн чанар сайжирч байгааг илтгэж байна.

Түүнчлэн 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтад хүний хөгжлийг дэмжих зорилгоор боловсрол, эрүүл мэндийн салбарт бүсчилсэн хөгжил болон хувийн хэвшлийг дэмжиж, бизнесийн орчныг сайжруулах хүрээнд эрчим хүч, суурь дэд бүтцийн салбарт гамшгийн эрсдэлийг бууруулж, үндэсний сөрөг тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор онцгой байдлын салбарт нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг хангах үүднээс батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүй, дотоод хэргийн салбарт шинэ хөрөнгө оруулалтыг түлхүү төлөвлөлөө.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Тухайлбал тус Байнгын хороонд хамаарах салбар буюу Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад 93.1 тэрбум төгрөг, АТГ-ын даргын багцад 1.7 тэрбум төгрөг, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн багцад 3.4 тэрбум төгрөг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 60.5 тэрбум төгрөг, Улсын Ерөнхий прокурорын 24.2 тэрбум төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгалаа.

Мөн олон улсын өмнө хүлээсэн үүргийн хүрээнд НҮБ-ын COP17 хурлыг зохион байгуулахад шаардлагатай санхүүжилт болон гадаадын зээл, тусламжийн төслүүдийн Монголын талын хариуцах хөрөнгийг төсөвт тусгалаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 31.6 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь зарлага 29.6 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 2 их наяд төгрөгийн ашигтай буюу ДНБ-ий 2 хувь байж төсвийн тусгай шаардлагуудыг бүрэн хангахаар байна.

Иймд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Баярлалаа.

Д.Цогтбаатар: Учрал сайдад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Маш олон хүн байгаа болохлоор би ингэе яг Байнгын хороонд харьяалагдаж байгаа байгууллагуудынхаа хүмүүсийг уншаад бусдыг нь би байгууллагаар нь уншаад танилцуулаад явчихъя. Оролцож байгаа хүмүүс нэрийг нь уншсангүй, үл хүндэтгэсэн гэж битгий үзээрэй. Энэ дуусахгүй юм болох гэж байгаа учраас юу.

Засгийн газрын гишүүн, Шадар сайд Учрал сайд оролцож байна. Улсын дээд шүүхээс Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга Заяадэлгэр, С.Заяадэлгэр, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, Улсын дээд шүүхийн ерөнхий нягтлан бодогч А.Эрдэнэцэцэг, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтулга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Наранбилэг,

Шүүхийн сахилгын хорооноос

Шүүхийн сахилгын хорооны дарга Ч.Ариунтуяа, Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны ерөнхий нягтлан бодогч Б.Ариунжаргал.

Хүний эрхийн Үндэсний Комисс

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Д.Ёндонжамц, Хүний эрхийн Үндэсний Комиссын ерөнхий нягтлан бодогч Б.Бадамсэрээжид.

Авлигатай тэмцэх газар

Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга Ж.Баасанням.

Улсын Ерөнхий прокурор

Улсын Ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Нарийн бичгийн дарга, Ч.Цасчихэр, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын Ажлын албаны дарга Л.Очирсүрэн гэсэн ийм хүмүүс байна.

Тэгээд би бусдыг нь байгууллагаар нь уншаадахъя. Хууль зүй, дотоод хэргийн яам. Цагдаагийн ерөнхий газар. Энд орж ирж манайхан улс төржихгүй шүү. Энэ Хууль зүйн байнгын хороон дээр орж ирж. Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Гадаадын иргэн харьяатын газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Архивын ерөнхий газар, Мэдээлэл шуурхай удирдлагын төв, Дотоод хэргийн их сургууль, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Хууль зүйн туслалцааны төв, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын алба гэсэн ийм байгууллагуудын төлөөлөл байна. Мөн түүнчлэн Сангийн яамнаас бас төлөөллүүд энд оролцож байгаа.

Ингээд хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцууллаа.

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч, Монгол Улсын Ерөнхий аудитор болон төслийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуух гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Ганбат гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье. Одоо яачихлаа Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Төсөв дээр манай Хууль зүйн байнгын хороо төсөвтэй холбоотой асуудлыг ганцхан Засгийн газар төсөв өргөн барьсны дараа хэлэлцдэггүй. Түүнээс өмнө хаврын чуулганы үед буюу чуулган хаахаас өмнө Шүүхийн ерөнхий зөвлөл болон Хүний эрхийн Үндэсний Комисс, Улсын дээд шүүхийн төсвийн төсөөллийг хэлэлцэж баталдаг. Тэгээд бүгдээрээ хууль тогтоомжийг мэдэж байгаа. Өнгөрсөн жил гэхэд Хүний эрхийн Үндэсний Комиссын 2026 оны төсвийг Хууль зүйн байнгын хороо хэлэлцээд нийт 30 орчим тэрбум төгрөгийн төсвийг бол бид нар баталсан.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Гэтэл энэ удаа төсөв нь өмнөх оныхоос дахиад буураад ороод ирсэн. Нэгдүгээрт үүнтэй холбоотой тайлбар хүсмээр байна. Хоёрдугаарт цаашид Цогтбаатар даргаа манай Байнгын хороо ингэж Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүх, Хүний эрхийн Үндэсний Комиссын төсвийг ингэж урьдчилж батлах ер нь ийм хэрэг байгаа юм уу, Төсвийн төсөөллийг ингэж батлах хэрэг байгаа юм уу? Төсөв биш тээ төсвийн төсөөллийг бид нар ингэж урьдчилж хэлэлцэж батлаад Сангийн яам руу явуулаад явуулсан ч бид нар хэчнээн төгрөг, хэчнээн ч асуудлыг ингэж баталсан байсан Сангийн яаман дээр очоод л буурдаг.

Тэгэхээр энийг яах юм хэдүүлээ энэ жил дахиад л энэ чигээрээ явах гээд байна шүү дээ. Өнгөрсөн жил энэ асуудлаар зөндөө хэлсэн, зөндөө Байнгын хороон дээр ярилцсан. Юу ч засагдахгүй байна шүү дээ. Юу ч өөрчлөгдөхгүй байна шүү дээ. Тэгээд манай Байнгын хороо энийг ингэж хэлэлцэх хэрэг байгаа юм уу? Хууль ингэж биелүүлэхгүй байж болох юм уу энэ Сангийн яам? Яах вэ одоо хэдүүлээ? Дахиад хойтон жил дахиад яг энийг ярих гээд, яриад л суух гээд байгаа байхгүй юу. Эсвэл манай Байнгын хороог эсвэл татан буулгах юм уу, эсвэл энэ хуульд өөрчлөлт оруулах юм уу, яах юм? Тэгээд энэ чинь эцсийн эцэст Засгийн газар шүүх эрх мэдэл гээд энэ шүүх эрх мэдлийн байгууллагын бие даасан хараат бус байдлын асуудал шүү дээ.

Тэгээд энд ингээд Сангийн сайдыг царай алдаад явж байдаг. Өнгөрсөн жил ямар байсан юм яг л тэр хэвээрээ. Одоо би Хүний эрхийн Үндэсний Комисстой холбоотой урсгал зардал нь буурчихсан өмнөх энэ 25 оныхоос. 1.5 тэрбум хэн сайдтай нь уулзаж хэнээс нь царай алдах уу гээд. Би үнэндээ Жавхлан сайд, Учрал сайд гээд энэ хэдэн сайд нарыг царай алдаж энэ төрийн байгууллагуудын төсвийг ингэж гуйж явдаг юмыг халмаар байх юм. Уг нь халах гэж манай Байнгын хороо ингээд энэ төсвийн төсөөллийг хэлэлцээд байдаг. Учрал сайд аа, Энхбаяр одоо сайд аа гэх юм уу, сайд болох гэж байгаа хүнээ гэх юм уу, нэр дэвшигч ээ гэх юм уу, горилогч оо гэх юм уу та хэд маань нэгнийгээ юм ярьж байхад жаахан хүндэтгэлтэй хандаач. Би түрүүнээс хойш минут гаран юм яриад л байна л даа. Тийм. Тэгэхээр би харин анхааралтай бие биеийнхээ яриаг битгий ингэж үймүүлээч гэдэг хүсэлт гаргаж байна та бүхнийг. Учрал сайдаас би асуулт асуусан. Тийм, тэгэхээр Учрал сайд аа манай Байнгын хороо ингэж урьдчилж хэлэлцдэгийг хэдүүлээ цаашид яах вэ? Энэ ерөөсөө яг хэлбэрийн.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Учрал сайдын микрофоныг өгье. Учрал сайд аа микрофоныг чинь өгчихсөн байгаа шүү.

Н.Учрал: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Тэгээд мэдээж энэ хараат бус байх зарчим байгаа. Тийм учраас ер нь Хууль зүйн байнгын хороонд харьяалагдаж байгаа, энэ салбарт харьяалагдаж байгаа байгууллагуудын төсөв дээр бол Засгийн газрын зүгээс бол тийм танах гэхээсээ илүүтэйгээр энэ бие даасан үйл ажиллагаа явуулахыг нь бас үргэлж хүндэтгээд л ингээд л төсвийг нь тавиад л ирсэн. Өмнө нь бол бас энэ чинь Хууль зүйн байнгын хороон дээр хэлэлцдэг шүү дээ.

Тэгэхээр тэр асуудал бол зарчмын хувьд, мэдээж эндээ хэлэлцээд, гол асуудлуудыг нь сонсоод ингээд төсвөө төлөвлөх нь бол ер нь зарчмын хувьд зөв юм байна лээ. Тэрнээс биш яг төсвийн үеэр гэнэт ингээд оруулж ирснээсээ илүү бас Байнгын хороогоор ингээд хэлэлцээд яг нөхцөл байдлыг нь сонсоод явах нь бас зарчмын хувьд бол зөв гэж бодож байгаа.

Гэхдээ хууль хяналтын байгууллагуудын бие дааж ажиллах, энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх энэ үйл ажиллагаагаа явуулахад бид бол төсөв танаад байна гэхээсээ илүүтэйгээр яг л энэ Хууль зүйн байнгын хороон дээр гарсан дүгнэлтүүд, нөхцөл байдлыг нь үндэслээд л ингээд төсвийг тавиад ирсэн. Энэ жилийн хувьд ч гэсэн бас хуулийн салбарт бүх боломж бололцоогоороо дэмжлэг үзүүлж үйл ажиллагаа явуулах бололцоог нь хангуулж ажиллаж байгаа. Тэгээд Сангийн яамнаас нэмж яг төсөв дээрээ хариулчихгүй юу.

Д.Цогтбаатар: Сангийн яамнаас бас хариулах нь зөв байх. 9 дүгээр микрофон. Сангийн яам. Өөрийгөө танилцуулаарай.

М.Санжаадорж: Сангийн яам, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Төсвийн зарлагын хувьд бол бүх л салбарын хувьд бол мэдээж хэрэг зовлон байгаа. Бид бол яадаг вэ гэхлээр 21 аймаг, нийслэл, дээрээс нь улсын төсвийн 38 төсвийн ерөнхийлөн захирч буюу нийтдээ 58 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг энэ орлогодоо багтаагаад оруулж ирж байгаа юм. Ингэж оруулж ирэхдээ бол бас иргэдээс хэлэлцүүлэг явуулж байгаа, явж байгаа. Орлогыг бол 3 байгууллага тооцчихоод Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам. Тэгээд хиймлээр бид нар орлого нэмээд тавих юм бол тэр дүн маань багтахгүй болчихож байгаа юм. Энэ жилийн хувьд хамгийн хэцүү байсан зүйл вэ юу гэхлээр автоматаар буюу хүн амын өсөлттэй холбоотойгоор нэмэгдэж байгаад нийт төсвийн хэмжээ маань 1 их наяд төгрөг болчихсон байгаад байгаа.

Гэхдээ урсгал зардлын хувьд 585 тэрбум төгрөг л нэмэгдсэн. Өөрөөр хэлбэл бүх төсвийн ерөнхий захирагч дээрээ ижил зарчмаар энэ маань буурч орж ирсэн.

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүн бас Хууль зүйн байнгын хорооны удирдлагаасаа асуусан учраас би энэ дээр тайлбар хэлье гэж бодож байна.

Нэг зүйл бол үнэн. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүхтэй холбоотой энэ төсвийг бид нар энд баталдаг. Тэр хуулиараа өөрчилж болдоггүй. Ямар тохиолдолд энэ асуудлыг Сангийн яам ингээд өөрчлөөд орж ирж байхад бид нар энийг авч үзэж байна вэ гэхлээр яг амьдрал дээрээ, бодит байдал дээр мөнгө гэдэг өөрөө хөдөлж байдаг. Инфляцаа дагаад л мөнгөний үнэ чинь өөрөө биднээс асуухгүй өөрчлөгдөөд явчихсан байдаг. Бид нараас асуухгүйгээр өөрчлөгдөж байгаа эдийн засгийн ухагдахуунууд байхад тэрийгээ тодотгох гээд үгүй энэ чинь ийм болчихсон байна. Тэгэхлээр энийг ингэж засахгүй бол яах аргагүй оруулж ирэхээс бас өөр үггүй тийм юмнууд байж болно. Тэр хэмжээнд нь бид нар хүлээж аваад үзэж болно. Түүнээс Засгийн газарт, Сангийн яаманд сануулж хэлэхэд Үндсэн хуульд Сангийн яам гэдэг ойлголт байхгүй шүү. Үндсэн хуульд шүүх гэдэг ойлголт байгаа. Тэгэхлээр шүүхийн төсвийг нэгэнт тэр баталсан бол энийг үнэхээр ягштал танайх бодож орж ирэх ёстой. Тэр дээр ингээд би байнга хууль сануулаад баймааргүй байна. Цаашдаа энийгээ бодож орж ир. Бид нар болох хэмжээндээ жишээлбэл сая Баасанжаргал гишүүний асуултад би та нарыг хамгаалж хариулж сууж байгаа байхгүй юу. Ингэх ёсгүй. Тэгэхлээр энийгээ цаашдаа та нар санаарай гэж би хэлмээр байна.

Баасанжаргал гишүүний микрофоныг. Баасанжаргал гишүүний микрофоныг өгье. Тодруулна.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Х.Баасанжаргал: Учрал сайдад би нэг зүйлийг тодруулж асуух гээд байна. Учрал сайдаас. Хуулийн байгууллага гээд бүгдийг нь багцалж болохгүй. Хууль зүй, дотоод хэргийн яамны сайдын багцаас гадна тусдаа Шүүхийн ерөнхий зөвлөл, Хүний эрхийн Үндэсний Комисс, Улсын дээд шүүх гээд ингээд холбогдох зарим байгууллагуудын төсөв бол Хууль зүйн сайдын багцаас тусдаа явж байгаа, нэг.

Хоёрдугаарт энэ тусдаа явж байгаагийн гол утга учир юу гэвэл энэ чинь Засгийн газрын аль яам бусад тэр 58 төсвийн ерөнхийлөн захирагчтай адилхан биш. Энэ чинь тусдаа эрх мэдэл, бие даасан эрх мэдэл гэдэг энэ Үндсэн хуулийн зохицуулалтын дагуу явж байгаа. Тийм учраас бусад бүх байгууллага, төрийн байгууллагатай битгий адилтгаж үзээч гээд байгаа юм. Тэгээд хассан гол үндэслэлийг л би гол нь сонсмоор байгаа юм. Байнгын хорооноос баталж явуулсан төсвийн төсөөллөөс бууруулж байгаа үндэслэл нь үндэслэл бүхий тайлбар ерөөсөө ирэхгүй байна.

Д.Цогтбаатар: Хэнээс Учрал сайд. Ганбат дарга 9 дүгээр микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Манай улс болохлоороо төсвийн хувьд бол нэгдсэн төсөвтэй улс. Нэг л эх үүсвэрээс өөрөөр хэлбэл санхүүждэг гэсэн үг. Өөрөөр хэлбэл манай улсын орлогын дийлэнх хэсэг маань бол татварын орлого л болчихоод байгаа. Тэгээд тэр орлогодоо бид нар нийцүүлж оруулж ирж байгаа. Түүнчлэн бидний хувьд бол мөнгөний бодлого болон төсвийн бодлого гэсэн 2 том бодлого энд бас цаад бодлогоороо хэрэгжиж байгаа. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр жишээ нь инфляцын түвшин байгаа. Засгийн газрын буюу Засгийн газраас гэхээсээ илүү төрийн нийт зарлага хэдэн төгрөг байхаасаа шалтгаалаад хувийн хэвшилд бас хэдэн төгрөгийн орон зай гарч ирэх вэ гэдэг асуудал орж ирнэ. Бага хүүтэй зээлийн олдоц ямар байх вэ гэдэг нь энэнээсээ хамаарч байдаг. Өөрөөр хэлбэл макро эдийн засгийн том бодлогууд маань бол өөрөө энэ төсвийн орлого, зарлагатайгаа бас ингээд хамт уялдаад явж байдаг. Ийм байгаад байгаа юм. Түрүүн миний хэлсэн түрүүний тайлбар маань л байна л даа 1 их наяд төгрөгөөр бид нар зарлага хасах шаард.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Гүйцээж хариулах уу? 9 дүгээр микрофон.

М.Санжаадорж: Баярлалаа. Бид 1 их наяд төгрөгөөр автоматаар ингээд хүний өсөлттэй холбоотойгоор зарлага нэмэгдүүлэх хэрэгтэй болсон учраас зөрөөд орлогоо хий нэмж чадахгүй учраас зарлагаа л хасахаас өөр аргагүй болсон. Ингээд зарлагаа бол бид нар нэмж, хасах шаардлагатай болсон. Энэ хүрээндээ бол бүх төсвийн ерөнхийлөн захирагч дээр бол ялгаагүй энэ дүндээ тааруулж оруулж ирсэн байгаа. Тэгээд төсөв маань өөрөө бүгд макро эдийн засгийн бас үзүүлэлтүүдтэйгээ холбоотой байдаг учраас ийм арга хэмжээ авахаас өөр аргагүй байдалд орсон.

Д.Цогтбаатар: Одонтуяа гишүүний микрофоныг өгье.

С.Одонтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр ажлын хэсгээс асуулт алга нэгэнтээ төсөв шилжсэн учраас. Би хүсэлт байгаа юм. Энд Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдорж сууж байна. Тусгай хяналтын хорооны дарга Б.Энхбаяр байна. Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар, манай Их

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Хурлын гишүүддээ хандаж бас хүсэлт байна. Энэ төсөвт хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх хөтөлбөр гээд ердөө 67-хон сая төгрөг тавигдсан байгаа юм. Энэ ямар ч хангалтгүй мөнгө. Өнөөдөр энэ асуудал ямар байдалд хүрчихсэн байгаа вэ гэдгийг бүх хүн мэдэж байгаа. Сүүлийн жилүүдэд Монгол Улсад энэ хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ болон хууль бус эргэлт нэмэгдэж байгаа. Жилээс жилд энэ гэмт хэргийн тоо 25-30 хувь жил болгон өсөж байгаа. Энд хэрэг төвөгт холбогдож байгаа хүмүүсийн 70 хувь нь 18-30 насныхан байгаа. Энэ чинь жоохон хүүхдүүд л байхгүй юу. Тэгэхээр бид энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж энэ урьдчилан сэргийлэх ажлаа хийхгүй бол байдал маш хүнд байдал руу сүүл рүүгээ орно оо. Тийм учраас би 2 тэрбум төгрөгийн ингээд хүсэлт гаргаад Төсвийн байнгын хороон дарга ажлын хэсгийнхэн дэмжсэн.

Тийм учраас би гишүүдийгээ бас чуулган дээр энэ асуудлыг дэмжиж өгөөрэй гэж хүсэж байгаа юм. Өнөөдөр хүмүүс хаана хандахаа мэдэхгүй энэ ингээд санаандгүй хар тамхи хэрэглэчихсэн хүмүүс хаана хандахаа мэдэхгүй, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх хүн байхгүй. Энэ хэдэн залуучууд ингээд бусад орны жишгээр бас ийм цуглаад зовлон, жаргалаа ярьдаг ийм бүлэг байдаг. Эд нарыгаа цуглаад суух газар байхгүй. Хүмүүс тэр болгон бас ил уулзаад байх боломжгүй иймэрхүү байдалтай байгаа. Тэгэхээр 2024 онд Улсын Их Хурлаас бид бас энэ дээр төсөв тавиад маш үр дүнгээ өгсөн гэж энэ бүх тайлангууд надаа ирсэн. Тийм учраас бид нар энэ дээр 2-хон тэрбум төгрөгийг тавих хэрэгтэй байна. Хөтөлбөр дээр. Тэр өөр зардлууд бол байж болно.

Гэхдээ хөтөлбөрөө хэрэгжүүлэхгүйгээр энэ хар тамхитай тэмцэх асуудал чинь хөдлөхгүй. Тийм учраас би Их Хурлын гишүүддээ энд хандаад хүсэлт гаргаж байгаа юм. Өнөөдөр би бол зарчмын зөрүүтэй санал хураалгах боломжгүй юм байна лээ. Яагаад гэхлээр юунаас хасах гэдгээ манай Төсвийн байнгын хорооныхон ажиллаж байгаа. Тэгэхээр энийгээ би Төсвийн байнгын хороон дээр хураалгаад чуулган дээр орж ирэхээр манай Байнгын хорооныхон бас дэмжээсэй гэж хүсэж байгаа юм. Өмнө нь Монгол Улсад энэ архинаас сэргийлэх энэ “АА” гэж бүлгэмүүд ажиллаад маш их үр дүн өгсөн байдаг юм. Тэр шиг бид нар энэ хар тамхины эсрэг тэмцэхгүй бол өнөөдөр олон нийтийн мэдлэг боловсрол маш доогуур байна. Энэ хор уршгийг нь бууруулах, энэ донтсон иргэдэд нөхөн сэргээх үйлчилгээ хийх, сэргээн засах энэ асуудлууд чинь огт хийгдэхгүй байгаа шүү. Тэгэхээр би энэ хүсэлтийг.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Одонтуяа гишүүн. Тэгэхлээр энэ чинь асуулт биш гишүүддээ хандсан санал байлаа гэж бодлоо. Би таны хэлж байгаа юмыг харин дэмжиж байгаа шүү. Яагаад гэвэл наадах чинь үнэндээ том асуудал. Ингээд энийг ярихгүй түрүүн Ганбаа, Ганбат гишүүн хэлж байна лээ л дээ. Тэмээн хяруул элсэнд толгойгоо хийчхээд өөрийгөө харагдахгүй гээд. Яг амьдрал дээрээ байна шүү дээ бид нар, хүн бид тийм юм хийх гээд байдаг байхгүй юу. Харин тэмээн хяруул тийм юм хийдэггүй байхгүй юу. Тэмээн хяруул тэгэхлээр зарим юман дээр биднээс ухаантай байх гээд байгаа байхгүй юу. Тэгэхлээр энийг бид нар нээрээ бодож энэ асуудлыг харахгүй явснаар асуудал шийдэгдэхгүй жинхэнээрээ энэ цаашаа даамжирч магадгүй байгаа учраас энэ дээр та төсвийн хороон дээрээ асуудлаа тавиарай. Тэгээд ярьж байгаад гишүүдтэйгээ яриад энийг явуулъя.

Ганбат гишүүний микрофоныг өгье.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Д.Ганбат: Тэмээн хярвалаас бид нар биш ээ та нар л дор болчхоод байгаа байхгүй юу. Нэгдүгээрт, асууя хөөш айн үгүй үгүй та л өөрөө эхэлсэн шүү дээ. Бид нар Хууль зүйн байнгын хороон дээрээ улсынхаа төсвийг ярьж байна. Хууль зүй, дотоод хэргийн сайд чинь хаана байна? Тэгээд ерөөсөө хариулахгүй юм. Хууль зүй, дотоод хэргийн сайдтай болох талаар юу хийж байна аа? Хэзээ болох юм бэ? Би эрх баригчдаас асууж байна. Бүгдээрээ л дарга болох гээд л гүйгээд байдаг юм байна лээ. Тэгээд ганц ерөөсөө энэ Засгийн газрыг би сүүлийн үед энэ гэмт хэрэгтэй тэмцэх гэж оролдоод байна гэж үзэж байгаа. Уул нь болсон өдрөөсөө эхлээд тэмцэх ёстой байсан байхгүй юу. Их оройтож тэмцэж байна. Тэгээд нэн яаралтай Хууль зүй, дотоод хэргийн сайдтай больё. Хууль зүй, дотоод хэргийн сайдгүйгээр бид нар энэ хууль зүйн салбарын төсөв хэлэлцэнэ гэдэг чинь учир дутагдалтай л байгаа байхгүй юу. Энэ асуултад хариулаарай.

Нөгөө талаар энэ шүүхтэй холбоотой төсөв яг хуулийнхаа дагуу орж ирсэн үү? Энэ чинь бас арай тусгай замаар явдаг шүү дээ. Хэн нэгэн Сангийн сайд ч юм уу, хэн нэгэн дарга энийг хасаж бариад байдаг юм байхгүй. Сая Үндсэн хуулийн цэцийн энэ юм хумнаас харж байхад энэ шударга ёс бүх юм тэр Цэц дээр, шүүх дээр л очиж нэг тийшээ болдог.

Нөгөө талаар энэ хууль зүйн салбарт энэ гэмт хэрэгтэй тэмцээд хууль бусаар хөрөнгөжсөн энэ хуулийн зүйл, заалт нь байгаа байх. Энэний дагуу хэчнээн хэмжээний мөнгө төгрөг орж ирж байна вэ, ирэх жил хэчнээн хэмжээний мөнгө орж ирэх юм? Би бас гайхаад байгаа. Тэр оффшор бүс гэж байгаа. Тэр Засгийн газар оффшор бүсээс Сингапурыг, Швейцарыг хассан гэдэг нь үнэн юм уу, хэзээ хассан юм? Ямар учраас хассан юм? Хэрэв тийм бол бусад нь оффшор гэж ямар үнэлгээгээр хасаад байдаг юм? Оффшорт тэр иргэд ярьж байна шүү дээ. Мэдээлж байна. 180 сая доллар тэр дансанд байж байна гээд. Тэр гүтгээд байгаа юм уу, эсвэл байгаа юм уу? Одоо энэ тендер шалгаруулж байгаа хэдхэн компаниуд л байдаг шүү дээ. Энэ нүүрсийг зөөдөг оффтейк гэрээ хийдэг ганцхан юм уу, хоёрхон компани л байна шүү дээ. Үгүй ээ энэ нүүрсний хулгайтайгаа яаж тэмцээд байгаа юм бэ? Энэ тэмцлийн үр дүнд ямар орлого орж ирж байгаа юм бэ гэдэг зүйлийг би асууя. Энэ ажлаа хийж байна уу, хийхгүй байна уу? Цэргийн албан хаагч бол тушаалд захирагддаг. Хуулийнхан хуульд захирагдах ёстой шүү дээ. Даргад биш, аль намд биш.

Д.Цогтбаатар: Хэнээс асуух вэ дарга? Шадар сайд Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Хууль зүйн байнгын хороонд манай хуулийн байгууллагуудын төсвийн талаар ярилцаж байгаа. Тэгэхээр төсөвтэйгөө холбогдуулаад нэмэлт мэдээллээ төсвийн ерөнхийлөн захирагч нар бас өгөх байх. Энэ Ганбат даргын санал маш зөв. Төсөв хэлэлцэж байх үед Хууль зүйн сайд томилогдох ёстой. Тэгээд Хууль зүй, дотоод хэргийн сайдаар Монгол Улсын Ерөнхий сайд Үндсэн хуулиар заагдсан онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдаар Баттөмөрийн Энхбаяр гишүүнийг нэр дэвшүүлсэн. Ингээд Их Хуралд танилцуулаад тангараг өргөснөөр ажилдаа орох ёстой. Тийм цаг хугацаа хангалттай байсан. Энэ төсөв яг хэлэлцэхийг, хэлэлцээд энэ ажлын хэсэг гаргах үеэр. Хууль зүйн сайдаар Энхбаяр гишүүн томилогдсоныхоо дараа энд асуудлаа өөрөө ярих ёстой байсан.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Гэтэл энэ Хууль зүйн сайдын томилгооноос болоод Засгийн газраар огцрох эсэх асуудал дээр ингээд тулчхаад байгаа юм. Тэгэхээр үнэхээр цаашдаа энэ чинь Их Хурал дээр ажлын хэсэг гарчихлаа. Энэ төсвийн болон ерөнхийлөн захирагч нарын энэ хууль зүйн салбарт хийгдэх олон шинэчлэл, энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал, энэ авлигатай тэмцэх энэ бодлого үйл ажиллагааг явуулахын тулд шинээр томилогдох Хууль зүйн сайд энэ үйл ажиллагаанд оролцмоор байгаа юм. Тэгээд одоо яг үнэндээ эзэнгүй болчихоод байна. Тэгэхээр Хууль зүй, дотоод хэргийн сайдыг томилох энэ Ерөнхий сайдын энэ бүрэн эрхийг хэрэгжүүлж Их Хуралд танилцуулах ажлыг маш яаралтай хийж өгөхийг бид нар хүсэж байгаа. Ингээд бичиг нь оччихсон ингээд л хүлээгдээд байгаа. Танилцуулаад л захирамж гаргаад л болоо шүү дээ. Тэгээд энэ чинь Ерөнхий сайдын олгогдсон эрх нь.

Тийм учраас бас Их Хурлын Байнгын хорооны дарга, Их Хурлын гишүүд та бүхнийг энэ Хууль зүйн сайдыг Их Хуралд танилцуулах ажлыг нэн даруй зохион байгуулах, туслалцаа үзүүлээч гэж хүсэж байна. Тэгвэл энэ Энхбаяр гишүүн бас энэ төсөв мөнгө рүүгээ орохгүй бол бас болохгүй байна шүү дээ. Энэ хуулийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч нар чинь хэнд асуудлаа ярихаа мэдэхгүй болчихсон ийм л нөхцөл байдалтай байна. Байнгын хорооны гишүүд ч гэсэндээ нэг талдаа гаргаад ингээд томилох, томилоод танилцуулах, танилцуулаад ингээд явж туслаач л гэж Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдээс хүсье.

Д.Цогтбаатар: Учрал гишүүн яана шүү Хууль зүйн байнгын хороон дээр байгаа учраас бид нар нэр томъёогоо зөв хэрэглэх ёстой. Та сая ороод ингэж байна шүү дээ. Ерөнхий сайд нэр дэвшүүлэх, санал дэвшүүлсэн гээд. Тийм биш шүү. Ерөнхий сайд томилох шийдвэрээ гаргаад, эцэслэн ёсчлох процесс дуусаагүй. Тэр нь танилцах л асуудал байгаа. Тэгэхлээр Ерөнхий сайд томилох шийдвэрээ гаргаад энэ танилцуулах процессоо л эхэлчихсэн. Танилцах процесс дуусаагүй, ёсчлох ажил дуусаагүй байгаа шүү. Тэгэхгүй бол нэр дэвшүүлнэ гэдэг бол Их Хурал батлах юм шиг, шийдвэрийг нь Их Хурал гаргах юм шиг болчихоод байгаа. Энэ тэнцвэрийн чинь балансыг Ерөнхий сайд руугаа 2019 онд шилжүүлээд өгчихсөн байгааг бас энд дурдаж хэлье.

Тэгээд Пүрэвдаваа гишүүний микрофоныг өгье. Байж байгаарай Ганбат гишүүн тодруулъя гэж байна. Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Би шүүхтэй холбоотой асуулт асуусан. Тэрийг хариулуулаарай.

Д.Цогтбаатар: Пүрэвдаваа гишүүнийг микрофоныг оруулаарай.

Д.Ганбат: Аль нь юм бэ айн? Тэгээд Хууль зүй, дотоод хэргийн сайд энэ Монгол Улсын төсөв хэлэлцэж байгаатай холбогдуулаад өөрийнхөө асуудлыг бас энэ дээр ярилцаж байх асуух ийм шаардлага байгаа юм. Тэгэхээр уул нь хуулиараа 4 дэх, Пүрэв, Баасан гарагт Улсын Их Хурлын чуулган явж байх ёстой. Өнөөдөр Пүрэв, гараг байх аа. Ямар нэгэн байдлаар хойшилж(урагшлаад явж байгаа байх. Даргын дэргэдэх зөвлөл гэж бий. Тэрүүгээрээ хэлэлцээд маргааш тэр юмандаа орсон уу ороогүй юу 5 дахь өдөр? Тэрийгээ үтэр түргэн оруул. Маргааш гэхэд Хууль зүй, дотоод хэргийн сайдыг нь танилцуулчих, тэгээд шийдээд яв. Бодвол Улсын Их Хурлын удирдлагагүй болчихоод байна уу? Тэгвэл дундаасаа нэг хүн тавьдаг юм уу хэдүүлээ айн? Манай Пүрэвдорж.../минут дуусав./

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Д.Цогтбаатар: Энэ дээр бас нээрээ тэгэхдээ Их Хурлын Тамгын газар бас анхаарч үзэх ёстой байх. Энэ асуудлууд ингээд гишүүдийн, тийм гишүүдийн асуулт бүгдэд нь ийм хариултгүй асуултууд байгаад байж болохгүй. Энэ дээр асуултууд байх ёстой байх. 5 дугаар микрофон өгье. Тэр шүүхийн тухай асуулт асуусан.

Н.Мөнгөнцэцэг: Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Сангийн яамнаас Шүүхийн ерөнхий зөвлөл өөрийн төсвийг боловсруулаад Хууль зүйн байнгын хороогоороо хянуулсан байгаад байгаа. Энэ хянуулсан төсвөө хүрээнд Сангийн яам руу хүргүүлсэн. Улсын төсөвт нэгтгэгдэх ёстой. Энэ хуулийн дагуу хийгдээгүй гэж хэлмээр байна. Тэгээд Хууль зүйн байнгын хорооны хянасан төсвөөс 60 хувь хасагдсан. Тэгээд гол Шүүхийн тухай хууль болон зарчим ерөөсөө шүүхийн төсвийг бууруулахгүй байх зарчимтай. Гэтэл энэ 25 оны батлагдсан төсөл, төсвөөс 29.8 хувь, 25 оны тодотголоос 16.2 хувь буурсан байгаад байгаа. Урсгал зардлын тухайд болохоор 13.2 хувь буурсан ийм үзүүлэлттэйгээр орж ирсэн байгаад байгаа.

Д.Цогтбаатар: Пүрэвдаваа гишүүний микрофоныг өгье.

Д.Пүрэвдаваа: Өдрийн мэнд хүргэе. Эдийн засаг, хөгжлийн яамнаас асуумаар байна. Нэгдүгээрт, энэ 26 оны төсвийн төсөл аль болохоор урсгал зардлыг хэмнэсэн, хөрөнгө оруулалтыг хэмнэсэн ийм төсөв гэж ойлгосон. Иргэдээсээ санал авсан. Тэгэнгүүт энэ 24 оны хүрээний асуудлыг би та бүхнээс хууль зүйн хувьд зөрчилтэй юу, үгүй юу гэж асуумаар байгаа юм. 24 онд төсөв нь эрс нэмэгдсэн сонгуулийн жил байсан. 24 оны төсвийг чинь 27 их наяд байсныг нь тодотгоод 30 болгосон. 23 оны төсөв миний санаж байгаагаар 20 их наяд орчим байсан. Тэгээд огцом 10 их наядаар нэмэгдүүлсэн. Энэ нь хууль зүйн хувьд ямар зөрчилтэй байсан юм. Зөрчилгүй байсан юм уу? Дараа дараа жил нь болохоор 30 их наядыг чинь 24 онд чинь 33 болгож 25 онд 33 их наядаар баталсан. Одоо 35 их наяд орчмоор орж ирж байх шиг байна. Тэгэхээр зэрэг энэ гэнэтийн өсөлт эдийн засагт хэрхэн нөлөөлсөн юм, та бүхэн маань ямар гэдэг юм алдаатай зүйлүүд дээр нь ямар хариуцлага тооцсон юм бэ гэдгийг асуумаар байгаа юм.

Хоёрдугаарт энэ багш, эмч нарын цалин гээд нийгэмд яригдаж байна. Төсвөө өргөн барьчихсан. Засгийн газар мэдэгдэл хийчихсэн. Бид нар ингээд тодорхой 10 хувиар хэмнэлт хийгээд ингээд багш, эмч нарынхаа асуудлуудыг шийднэ гэсэн. Тэгэхээр хэдэн жилээр та бүхэн маань төсөөлсөн юм? Энэ жил ингээд 800 тэрбум төгрөгийг эх үүсвэр болоод нэг талаас нь хасаад нөгөө талд нь нэмнэ гэсэн байна. Тэгэхээр ер нь цаашдаа бид нар сургууль, цэцэрлэг барина гээд жил болгон л 30, 40 сургууль цэцэрлэг барина гээд байгаа юм. Энэнтэйгээ уялдсан тэр багш нарын цалин, боловсон хүчний бодлого, эдийн засгийн үр өгөөжийн хувьд яаж тооцож байгаа юм? Хөдөө орон нутагт багшийн ачаалал эрс бага. Дунджаар сумд 10 орчим сурагчтай байна. 25 жилийн нэмэгдэл, анги даасны нэмэгдэл эд нар гээд харах юм бол үндсэн цалингаа бараг double-даад авах тийм боломжтой байдаг. Эдгээр дээр та бүхэн маань богино болон дунд хугацаандаа ямар бодлого барьж байгаа юм, өнгөрсөнд ямар алдаа гаргасан учраас өнөөдөр энэ тулгамдсан асуудал бий болоод байгаа юм гэдгийг та бүхэн маань тооцооллын бөгөөд хууль зүйн хувьд хариулаач гэж хүсэх байна. Тэгээд тодруулъя.

С.Одонтуяа: Пүрэвдагва гишүүний асуултад хариулъя Учрал сайд.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Н.Учрал: Жил бүр улсын төсвийг өргөн мэдүүлэхдээ бид нар энэ Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагуудыг бас чанд барьдаг. Дээрээс нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангуулж байгаа. Дээрээс нь мэдээж төсвийг төлөвлөхдөө олон хуулиар заачихсан зарим төсвүүдийг ингэж хуваарилж байгаа. Жишээ нь нийгмийн хамгаалал, энэ нийгмийн даатгалтай холбоотой, тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой асуудлууд хуулиар зохицуулчихсан учраас тэр хуулийг нь биелүүлж өргөн барьдаг.

Тэгэхээр тэр төсөв чинь өөрөө бол хууль болж өөрөө батлагдаж байгаа гэсэн үг. Гүйцэтгэлийг нь аудит Их Хурлаар хэлэлцүүлдэг. Тэгэхээр мэдээж гүйцэтгэлийг бол аудит өөрөө та бүхэнд бол аудитын байгууллагаас танилцуулсан гүйцэтгэл ямар түвшинд байгаа вэ гэдэг дээр. Өнгөрснөө эргээд харвал 2023, 2024 онуудад өнөөдөртэй харьцуулахад эдийн засгийн өсөлт өндөр байсан. Экспортын бүтээгдэхүүний үнэ өндөр байсан. Энэ ч утгаараа бид нар орлогыг их өндөр төлөвлөсөн. 33.5 их наядын орлого олноо, төлөвлөөд төдий хэмжээгээрээ зарна гэж төлөвлөсөн буюу алдагдалгүй төсөв гэж бид хамтдаа Их Хурлаар баталсан.

Гэтэл энэ тодорхой бус байдал дэлхийн түвшинд бас нэлээд өндөр болсон. Тэгээд үүнээсээ болоод энэ экспортын бүтээгдэхүүний үнэ төсөөлснөөс их багассан. Тийм ч учраас бол зайлшгүй тодотгол хийе гэдэг зорилгоор тодотгол хийхдээ бол хэмнэлт хийсэн. Ингээд хэмнэлт хийгээд ирэх жилийн төсвөө 9 сарын 1-ний өмнөөс өргөн мэдүүлье гэхээр өмнө нь батлагдсан төсвийн хүрээн дээр байгаа тоонууд бас хэт өөдрөг төсөөлчихсөн. Нэг ёсондоо Их хуралдай болоод төсөвтэй тийм худлаа ярих нөхцөл үүсэж байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ макро тоонуудаа зайлшгүй цаг үеийнхээ нөхцөл байдалдаа тааруулаад бодит тоо руу хөрвүүлэх шаардлагатай болж эхлээд. Тэгээд та бид хамтдаа тэр Төсвийн тогтвортой байдлын хууль дээр орлого, зарлагыг нь аль алиныг нь бууруулбал төсвийн хүрээг хамт өргөн мэдүүлж болох энэ нөхцөлийг бүрдүүлээд ингээд сая бид нар төсвийн хүрээгээ өргөн барихдаа 33.5 их наядаар орлого, зарлагаа төлөвлөсөн байсныг аль алиныг нь бууруулаад ингээд энэ удаа орж ирсэн. Яах вэ ер нь өнгөрсөн хугацааны оруулж ирж байсан төсвүүдээс бол гол ялгаатай зүйл нь бид нар энэ удаа маш тийм бодитойгоор тоонуудаа оруулж ирсэн. Тэгээд тийм орон зай ч гэсэн байхгүй. Яг үнэндээ ингээд багш, эмчийн цалин нэмэх боломж байхад нэмээгүй гэдэг ийм асуудал бол ярихад бол бас зохимжгүй. Яагаад гэвэл бид нарт тийм орон зайн тийм нөөц ч байхгүй. Үнэн нь тэр.

Гэхдээ одоо ямар байдал руу шилжиж байна вэ гэхээр Их Хурлын ажлын хэсэг нэгэнт ингээд Засгийн газар төсвөө өргөн мэдүүлээд Их Хурал руу хэлэлцүүлэг рүү явуулчихсан. Одоо Их Хурлын ажлын хэсэг бол хэрвээ энэ төрийн захиргааны төв байгууллагууд дээр хэрэгжих боломжтой төрийн үйл ажиллагаануудыг заримыг нь зогсоогоод урсгалаа танаад ингээд энэ 840 тэрбум төгрөгийг гаргаад ирвэл Засгийн газар татгалзах зүйлгүй юм гэдгээ л Их Хурлын Төсвийн байнгын хороонд илэрхийлж байгаа юм. Нэг ёсондоо бид нар их тийм зүгээр хэмнэлт хийе, эсвэл зарим үйл боломж байхад хийгээгүй гэдэг ойлголт огт биш. Зүгээр ер нь хийгдэх ёстой ажлуудаа заримыг нь зогсооно. Ингэснээрээ ер нь макро тоонууд руу ч хөдлөх ийм эрсдэл үүсэж байгаа л гэдгийг бас хэлье.

Д.Цогтбаатар: Пүрэвдаваа гишүүний микрофоныг гүйцээж өгье.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Д.Пүрэвдаваа: Би тодруулчихъя. Хариуцлагын асуудлыг та бүхнээс бас лавлаж асуумаар байна. Хэт өөдрөгөөр төсөөлөөд төсвийнхөө зардлыг эрс нэмчихсэн. Тэгээд энэ алдаатай бодлого байсан гэдгээ хэлчихсэн. Тэгээд хэн хариуцлага үүрэх юм бэ? Өнгөрсөн хугацаанд МАН 10 жил төр барьж байна. Ямар нэгэн өөр улс төрийн хүчинд бурууг нялзаах боломж байхгүй. Танай томилсон сайд, дарга нар үйл ажиллагаагаа хийж байсан. Тэгээд хариуцлагын системийг та бүхэн маань яаж харж байгаа юм, хэн хариуцлага тооцсон? Одоо энэ багш, эмч нарын бухимдалтай байдал мөн адил. Өргөн барихдаа болохоор боломжгүй гэхсэн. Одоо болохоор боломжтой гэхсэн. Хэн хариуцлага үүрэх юм?

Д.Цогтбаатар: Шадар сайд хариулъя.

Н.Учрал: Тэгээд ер нь олсныхоо хэрээр үрдэг, тэгээд эдийн засаг тэлж байх үед хэмнэж чаддаггүй, хуримтлал хийж чаддаггүй зөвхөн ингээд эдийн засаг агшчихсан үед л энэ мөчлөг сөрнө гэж ярьдаг. Яг ингээд эдийн засаг өсөөд ирэхээр энэ бодлогоо хэрэгжүүлж чадахгүйгээсээ болоод л ийм байдалд оччихлоо шүү дээ. Тэгээд нэрлэсэн ДНБ-ээ худлаа өсгөөд, тэгээд хоосон төлөвлөөд ингээд яваад байдаг. Тэгэхээр энэ удаа бид нар энэ макро тоонуудыг үнэнээр л төлөвлөө гэж зорьсон. Хэт өөдрөгөөр биш шаардлагаа барья л гэж зорьсон. Урсгал нэмэхгүй л гэж зорьсон. Яг энэ шаардлагуудаа бариад ороод ирэхэд багш, эмчийн цалинг багтаах орон зай байхгүй л байхгүй даа. Цаашаа эдийн засгаа эрүүлжүүлээд авч явъя гэвэл. Одоогийн нөхцөл байдал ийм байгаа үед Их Хурал үнэхээр улс төрийн шийдвэр гаргаад тэр урсгалыг жилийн төлөвлөгөөнд зааснаа 25 руугаа 1 хувь ч юм уу нэмээд ингээд.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 1 минут гүйцээгээд өгье Шадар сайдад.

Н.Учрал: Тэгэхээр жилийн төлөвлөгөөнд заасан урсгал 24 хувиас хэтрэхгүй шүү гээд. Хуульдаа болохоор GDP-ийн 30 хувь гэхсэн. Жилийн төлөвлөгөөнд 24 гэхсэн. 24-ийг 25 байлгаж болно оо гээд Их Хурал зөвшөөрөөд жилийн төлөвлөгөө нийцэж байна гээд явбал 840 тэрбумыг гаргаад энэ яамнууд дээр байгаа зарим үйл ажиллагааг нь хүчээр л зогсооно гэсэн үг шүү дээ. Зогсоогоод тэгээд тэр цалин нэмэх асуудал руу хийгээд явах гарц л байгаа. Тэрнээс биш яг зүгээр цаашдынхаа ирэх жилийн эдийн засгийг эрүүл байлгахаа бодож үзвэл энэ буруу гэдэг нь ойлгомжтой л доо. Тэгэхээр үнэхээр улс төрийн шийдвэр гаргавал өөр орон зай байхгүй. Тэрнээс Засгийн газар өргөн мэдүүлэхдээ боломж байхад шийдэж чадаагүй гэж ярих ямар ч бололцоо байхгүй. Угаасаа хөнжлийнхөө хэрээр л хөлөө жийж, цаашаа эдийн засгаа зөв авч явъя, эрүүлжүүлье гэдгээр л энэ тоондоо л хатуу байсан. Их Хурлын л улс төрийн шийдвэр.

Д.Цогтбаатар: Пүрэвдаваа гишүүн бас тодруулъя.

Д.Пүрэвдаваа: Нэг асуултад хариулсангүй. Хөгжлийн яам ирээдүйд, дунд хугацаанд Монгол Улсын жишээгээр дунд сургуулийн тоо, нийт багш нарын тоо хэд гэж төсөөлж байгаа юм? Жил болгон төсөв дээр Наранбаяр сайд бид нар өөр эх үүсвэрээр сургууль, цэцэрлэг барина. 40 орчмыг барина гээд мэдээлэл өгч байсан санагдаж байгаа юм. Тэгээд жил болгон хэд орчим сургууль баригдаж байж энэ тулгамдсан асуудал шийдэгдэх юм? Энэнтэйгээ уялдсан эдийн засгийн тооцооллоо яагаад танилцуулахгүй байгаа юм бэ? Хариулт авъя.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Д.Цогтбаатар: Учрал сайдаас энэ асууж байх шиг байна. Сангийн яам 9 дүгээр микрофон.

М.Санжаадорж: Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиар заасны дагуу 5 жилийн төлөвлөгөө байдаг. Тэр нь бол дараа нь Засгийн газрын мөрийн хөтөлбөр гэж байгаа 4 жилээр төлөвлөж байгаа. Дээр нь Төсвийн хүрээний мэдэгдэл байгаа 3 жилээр. Тэгээд жилийн төсвийн төсөөлөл бол орж ирдэг.

Сургууль, цэцэрлэгийн хувьд бол хүүхдийн тооны өсөлттэй холбоотойгоор бол бид нар гүйцэхийн тулд одоо хэрэгцээтэй байгаа зүйл бол 108 сургууль барих шаардлагатай байна гэсэн тооцоо Боловсролын яамтай нийлээд тооцсон. 28 сургуулийг бол нурааж шинээр барих шаардлагатай болчихоод байна гэж тооцсон байгаа. Бид улсын төсвийн хөрөнгө оруулалтаасаа бол бүх энэ сургууль, цэцэрлэгийг барьж угаасаа амжихгүй, энийг гүйцэхгүй.

Тийм учраас бид нар энийг нэг далайлтаар яаж хийж чадах вэ гэдэг дээр бүх төрлийн эх үүсвэрийг л ашиглая гэж байгаа юм. Тийм учраас гадаад зээлийн эх үүсвэрийг ашиглаад ирэх жил бол энэ сургууль, цэцэрлэгээ бариад энэ хойноос нь гүйцэтгэж үзье гэдэг асуудал. Дараачийн ээлжид.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Гүйцээж хариульъя 9 дүгээр микрофон.

М.Санжаадорж: Дараагийн ээлжид бол мэдээж хэрэг энэ газрын хомсдолтой нийслэлийн асуудал дээр бид нар сургууль, цэцэрлэгийг яаж гүйцэх вэ гэдэг асуудал бас өөрөө босож ирж байгаа. Тэгэхлээр бид нар хувийн сургуулиудыг нэгдүгээрт дэмжих асуудал байна.

Хоёрдугаарт түрээсийн сургуулийн асуудлууд орж ирж байна. Төрийн өмчийн барилга биш өөр барилгыг түрээслэх замаар эндээ бол сургуулийн үйл ажиллагааг, энэ стандартыг хангаад хэрэгжүүлэх ийм асуудлууд орж ирж байна. Нөгөө талдаа зөвхөн сургуулиас гадна боловсролын чанар гэдэгт бол багшийн асуудал орж ирж байна. Одоо Их Хурал дээр багшийн цалинг нэмэх бол асуудал бол яригдаж байна. Тэгэхлээр багш нь бас өөрөө боловсон хүчин нь яаж гүйцэх вэ гэдэг асуудал яригдаж байна. Орон нутагт дотуур байрны асуудал яригдаж байна. Ингээд цогцоор нь бол асуудлыг авч үзэж байгаа гишүүн ээ.

Д.Цогтбаатар: Учрал сайдын микрофоныг бас гүйцээж өгье.

Н.Учрал: Жилийн төлөвлөгөөнд 108 сургууль гэсэн тооцоо гарсан юм байна лээ шүү дээ. 108 батлагдсан жилийн төлөвлөгөөнд. 108 сургуулийг улсын төсвөөр баривал бид нарт 10 мянган, багадаа 10 мянган дунд сургуулийн багш байна уу? Бодох л ёстой. Цэцэрлэгийг шийдсэн арга зам бас зөв байжээ. Хувийн цэцэрлэгүүдтэйгээр Энх-Амгалан сайдын үед шийдчихсэн зам зөв байсан. Дунд сургуулийг энэ замаар шийдье гэхээр энэ чинь бас гишүүд шүүмжлээд байгаа шүү дээ. Эсвэл ер нь бүх юмыг өөрсдөө хийдэг, хуушуур, буузаа өөрсдөө жигнэдэг, бараг бүгдийг хийдэг улс болох юм уу? Тэрийг бол Их Хурал шийдэх ёстой байх. Зарим гишүүд их шүүмжлэлтэй байдаг учраас төр бүгдийг хийх ёстой гэдэг зарчимтай гишүүд давамгайл байгаа учраас хариулт байхгүй байна.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

П.Сайнзориг: Би 3, 4 асуулт байна. Нэгдүгээрт, Учрал сайд маань би багш, эмч нарын цалинг нэмнэ гэдэг дээр байр суурьтай байгаа. Нэмэх энэ санхүүгийн эх үүсвэрийг гаргах асуудал энэ сайд нарын багц буюу төсвийн ерөнхийлөн захирагчдын багцаас 10 хувь танана л гэж байгаа юм. Сая Учрал сайд маань хэлж байна Улсын Их Хурлын бүрэн эрх гээд. Энэ бүрэн эрхийг нь мэдсээр байж яагаад Засгийн газар улс төрийн шийдвэр гаргаад бид өргөн бариагүй байж байж нэмнэ гээд ингээд улс төрийн мэдэгдэл хийгээд зогсоод байдаг юм бэ хууль зөрчөөд? Та урсгал зардлыг 24 хувиар баталчихсан гээд байж байж энэ боломжгүй гэдгийг байгаа учраас ингэж орж ирсэн гээд байгаа байхгүй юу. Тэгээд яагаад ингээд хуралдаад энэ мэдэгдлүүдийг хийгээд байдаг юм. Би ойлгохгүй байна л даа. Үнэхээр ингэх гэж байгаа асуудлыг шийдье гэвэл урсгал зардлыг 25 болгоод өгөөч гээд хуулиа гялс яаралтай горимоор өргөн барьчих л даа. Бид хэлэлцье. Тэгэхээр ийм парламент руугаа ингэж бас бүх бурууг чихдэг энэ хандлага үнэхээр таалагдахгүй байна шүү та нөхдийн, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, сая ер нь зүгээр парламентын шийдвэр ямар ч үнэ цэнгүй гэдгийг Шүүхийн ерөнхий зөвлөл хариулчихлаа шүү дээ. Энд бид хэд шүүхийн төсөв, Улсын дээд шүүхийн төсөв батлаад явуулдаг. Тэнд нь юу ч биелүүлэлт байхгүй, ямар ч үндэслэл, тайлбар байхгүй. Ер нь зүгээр энэ парламентын дээр Засгийн газар гарчихсан гэдэг нь энэ үйлдлээр байхгүй юу. Би Сангийн яамныхаа нөхдүүдийг мэднэ. Зовлонг нь ойлгож байгаа.

Тэгэхдээ шүү манайхан нэгдсэн төсөв гэдэг чинь бүх юмыг Засгийн газар мэднэ гэсэн үг биш. Монгол Улс парламентын засаглалтай орон шүү. Парламент шийдвэрээ гаргаад та нөхдөд өгч байхад ямар ч үндэслэлгүйгээр хасчхаад ийм байдлаар ингээд ер нь энэ Хууль зүйн байнгын хорооны шийдвэр чинь юм гээд сууж байгаа чинь болохгүй шүү. Энд бид хэд бас үнэхээр энэ зүйлд хөл, толгойнууд нь байр нь солигдчихоод байгаа учраас ийм зүйл явж байна.

Хоёрдугаарт, 1 зүйл байна. Төсөв асуудал дээр сая зүгээр хариулт байна. Одоо нийслэл дээр газрын асуудлууд нь шийдэхгүй байсаар сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх хэцүү гээд. Тэгэхээр уг нь Засгийн газрын зарим санаачилгууд баймаар байна. Яагаад хувийн хэвшил 5, 6 давхар, 5 давхар Ерөнхий боловсролын сургууль барьж болдог, улс 2 давхраас илүү барьж болохгүй гэж байгаа юм. Хүүхдийн аюулгүй байдал, бусад юмаа тооцож байгаад наад захын стандарт өөрчлөхөд бид нарт уг нь боломжууд байгаа байхгүй юу. Тэгээд ч хийхгүй. Тэгсэн мөртөө ингээд л бие бие рүүгээ ингээд л худлаа хэлцгээгээд л ингээд л байж байдаг. Хамгийн хэцүүнүүд нь л энэ л байна.

Тэгэхээр би Сангийн яамнаас энэ АМНАТ-ын орлогыг бас асууя гэж бодож байна. Засгийн газрын 2025 оны 55 дугаар тогтоолоор АМНАТ-ын орлого яг буурсан эсэх асуудлыг Улсын Их Хуралд үнэн, зөвөөр Сангийн яам хэлээд өгөөч. Битгий мэлзээрэй. Энэ Улсын Их Хуралд үнэн, зөв хариулт өгөх ёстой шүү гэдэг зүйлээсээ. Архины сан байна. Сая Одноо гишүүн маш чухал асуудлыг ярилаа мансууруулах. Гэтэл энэ мансуурах.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Гүйцээгээд авах уу? Учрал сайд. Учрал сайдын микрофоныг өгье.

Н.Учрал: Төсвийн тогтвортой байдлын хуулийн тусгай шаардлагуудыг энэ удаагийн төсөв барьсан. Хэрвээ энэ макро тоонуудаа гаргаж өгч байгаа Эдийн

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

засгийн яам энэ хэдэн багшийн, эмчийн цалинг бусад асуудлуудыг шингээчихье, улс төргүйгээр энийг аваад гаръя гэвэл хий хоосон ингээд баахан ДНБ-ээ нэмээд л, худлаа орлого төлөвлөөд л, зарж чадахгүй юм байж байж тэр нүүрснийхээ үнийг өндрөөр тавиад л ингээд л өөдрөг төсөөлөөд л орж ирвэл тэгээд л галгүй аваад л гарах байх. Гэхдээ Эдийн засаг, хөгжлийн яам бол үнэнийг л хэлье гэсэн. Нүүрс чинь 70 доллараас илүү зарагдахгүй. Ийм болчихлоо. Яах вэ алт, зэсийн агуулга дээрээ жоохон найдъя. Тэрний тулд хийх вэ? Дээрээс нь өнөөдөр та бод доо энэ нэрлэсэн ДНБ, орлого хоёрын чинь харьцаа 37 хувьд хүрчхээд байна шүү дээ.

Тэгэхээр энэний чинь орон зайд хувийн хэвшил яаж ажиллах юм? Одоо энэ төрийн, төрд ажиллаж байгаа энэ төрийн албан хаагчдынхаа цалин хөлс, ажлын байрны тогтвортой байдлыг ярьж байгаад хувийн хэвшилд байгаа ажлын байраа яаж хадгалж үлдэх вэ гэдгийг мартаж болохгүй шүү дээ.

Тийм учраас тэр орлого, зарлагын харьцаа чинь өнөөдөр 37 хувь болчихоод байгааг энэ удаагийн төсөв дээр 30 хувь болтол нь бууруулъя. Тэгээд 28 онд 28 хүргэе л гэдэг ийм л зорилготой. Тэгэхээр энэ орон зайд тэр хувийн хэвшил ажиллаасай л гэж энэ шаардлагуудаа барьсан. Харин Төсвийн тогтвортой байдлын хууль дээр урсгал зардал бол 30 хувь гээд заачихсан байдаг хууль дээр. Гэтэл жилийн төлөвлөгөөнд чинь 24 гэхсэн байгаа байхгүй юу.

Тэгэхээр Сайнаа гишүүний хэлж байгаагаар жилийн төлөвлөгөөнд тусгагдсан тэр 24-ийг 25 болгоход л 1 их наядын орон зай гарчих л юм байна лээ л дээ. Ингээд явъя гэхээр жилийн төлөвлөгөөгөө барья л гэж анх зорьчихгүй юу. Тэрнээс биш Засгийн газар бол юу вэ гэхээр сая багш, эмч нар, багш нарын үйлдвэрчний эвлэл Ерөнхий сайдад шаардлага тавьж байгаа юм. Уулзъя, асуудлаа ярья. Тэгэхээр Ерөнхий сайд надаас хальчихсан. Энэ бол Их Хурлын ажил гээд суух эрхгүй шүү дээ. Ерөнхий сайд уулзах ёстой. Багш нар үйлдвэрчний эвлэл шахалт үзүүлж байна, уулзъя гэж байна. Тэгээд Ерөнхий сайд гэх юм. Энэ Их Хурлын ажил надад хамаагүй болсон гэж хэлэх эрхгүй шүү дээ. Энэ хүн чинь гүйцэтгэх засаглалын тэргүүн. Уулзсан. Уулзахдаа энэ цаашдаа Их Хурлын ажил учраас Төсвийн байнгын хорооны даргыг уриад, Сангийн сайдыг уриад ингээд Эдийн засаг, хөгжлийн сайд, Боловсролын сайд, Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд уриад Төсвийн байнгын хорооны даргатай, Зарлагын дэд хорооны даргатай хамт уулзаад асуудлаа ярьж байгаа юм. Тэгээд нэгэнт Их Хурал руу хэлэлцүүлэгт оччихсон учраас Засгийн газрын зүгээс зарим үйл ажиллагаагаа танаад урсгал дээрээ ингээд танаад Их Хурал шийдчихвэл ингээд бид нар зарим үйл ажиллагаагаа зогсоогоод явахад бэлэн л гэдгээ илэрхийлсэн. Нэг ёсондоо Төсвийн байнгын хорооны дарга одоо бид энийг чинь ингээд урсгалыг чинь хасаж болох юм уу? Дээрээс нь ингээд зарим үйл ажиллагаа зогсоход хүрнэ шүү. Болох юм уу гэхээр үнэхээр Их Хурал ингэж шийдвэл бид бэлэн гэдгээ, багш, эмч нар маань ингээд шахалт үзүүлж байна бид бэлэн гэдгээ Ерөнхий сайд илэрхийлсэн.

Тэгэхээр энэ ямар нэгэн шийдвэр гэхээсээ илүүтэйгээр Их Хурлынхаа Байнгын хороотой, гишүүдтэйгээ хамтраад ажиллаад явъя. Их Хурал дээр ч гэсэн ажлын хэсэг байгуулахад энэ Сангийн яамныхан л ажиллаж л байгаа шүү дээ. Тэгэхээр нэгэнт Засгийн газрын зүгээс үгүй гэсэн зүйл байхгүй гэххэж байгаа бол Их Хурал ажлаад явах нь нээлттэй ингээд даваад гаръя гэж байгаа юм. Хэдүүлээ ингээд төсөв хэлэлцэж байгаа учраас юунаасаа ийм тойрчихсон вакумаасаа салаад хэдүүлээ ажил хийхгүй бол Сайнаа заавал намайг шүүмжлэх ёстой юм шиг юм яриад хэдүүлээ хэрэггүй зүгээр ажлаа хий.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Сангийн яам 9 дүгээр микрофон.

Ч.Чимэдцэрэн: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. АМНАТ-тай холбоотой орлогын мэдээлэл бол ер нь 3.8 их наядыг 25 онд бол төсвийн орлогод бүрдүүлэх ёстой. Одоогоор 70 гаруй хувийн гүйцэтгэлтэй явж байгаа. Ингээд Монгол Улсын Засгийн газрын 25 оны 55 дугаар тогтоолтой холбоотой асуусан асуултад хариулъя. Энэ Монголын хөрөнгийн биржээс ирүүлсэн мэдээлэлд үндэслээд үзэхэд 6 компани дээр энэ ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн дүн нь энэ 55 дугаар тогтоол батлагдсанаас өмнөх нөхцөл байдлаас 8 дугаар сард бол 4.9 тэрбум, 9 дүгээр сард 8.3 тэрбумаар нийт 13.1 тэрбумаар бол буурсан байна.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье. Тодруулъя.

П.Сайнзориг: Би 2 асуултыг гялс амжаад асуугаадахъя. Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүх дээр бид нар энэ Хууль зүйн байнгын хороо хянагдсан төсвийг хүргүүлдэг зарчмыг Аудитын газартай жишиж хийсэн юм. Би өөрөө хуулийг нь бичсэн учраас мэдэж байгаа. Аудитаас хүргүүлсэн санал хэдэн хувиар хасагдаж төсөв дээр суусан бэ? Энийг Сангийн яам яг хариулаадах. Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүхийг хасчихдаг юм байж нэгдсэн төсөвтэй гээд. Аудитыг яг хэдэн хувиар хасчихсан байна? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ Архины сан гээд яг энэ мансуурсан, дэлгэцийн донтой, тоглоомын донтой, архины донтой хүмүүсийн эмнэлгийн асуудлыг нь шийдэх гээд ийм тусгай сан байгуулаад энд 20 тэрбум төгрөгийн асуудал бүрд сан байгаад байгаа юм. Тэгээд хувийн хэвшил энэ удирдах зөвлөлийнх нь 50 хувийг бүрдүүлдэг. Өөрөө архи үйлдвэрлэгч нар. Гэтэл энийг нь ерөөсөө зарцуулалтыг нь хийж өгдөггүй ийм зүйл байгаад байдаг. Тэгээд мансууралттай тэмцье, архидалттай тэмцье гээд байдаг. Яах гээд байгаа юм, бүгдийг нь шоронд хийх гээд байгаа юм уу эсвэл энэ бодлого чинь? Тэгээд.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Хэнээс асуусан бэ? Сангийн яам хариулах уу? 9 дүгээр микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Тэгэхлээр төсвийн процесс маань цаглаврынх нь дагуу Төсвийн хүрээний мэдэгдэл батлагдсанаас хойш төсвийн хязгаарыг 7 сарын 1-нд хязгаарыг батлаад төсвийн ерөнхийлөн захирагч нар хязгаартаа багтааж төсвийн саналаа ирүүлэх эрхтэй болдог.

Тэгэхээр, өөрөөр хэлбэл яг энэ хуваарилсан хязгаартаа багтаагаад аудитын байгууллагаас бол саналаа ирүүлсэн. Би яг тоог нь нарийн танд харж байж хэлэхгүй бол яахгүй байна. Архины сантай холбоотой асуудал бол тийм энэ сан дээр бол хөрөнгө төвлөрчхөөд байгаа юм. Тэгээд зориулалтынх нь дагуу зарцуулъя гэхлээр зарлагын хязгаартаа тулчхаад нийт зарлага дотроо орон зай гарч чадаагүй ийм л асуудал байгаа. Одоо бол тэгэхлээр шийдэл нь ямар зардал, зүйл байна гэхлээр Хууль зүйн сайдын багц дотроо л өөр зардлаа бууруулах замаар багтаах л ийм л шийдэл болчихоод л байна л даа. Тийм.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье. Тэгэхээр яг энэ л бөөрөнхийлж байна. Аудитыг та нар арай өөр нүүрээр харж байгаа, мэдэж байгаа. Уг нь энэ Үндсэн хуульд заасны чинь дагуу засаглалын нэг салаа мөчир нь шүүх эрх мэдэл байхгүй юу. Ингэж бас алагчилж, дэндүү ингэж бас болохгүй. Тэгээд энэ Улсын Их Хурал тэр дундаа Хууль зүйн байнгын хорооны шийдвэрийг үгүйсгэж байгаа бол Засгийн газар угаасаа энэ парламентын дээр гараад суучихсан гэдгийг удаа дараагийн үйлдлээр харуулж байна шүү дээ. Нэгдүгээрт.

Тэгээд Монгол хүн хамгийн том мега төсөл гэхээд энэ залуучууд чинь мансуурал, архидалтад живчхээд байхад энэнийх нь бодлого буюу эмчилье гэдэг тэр мэргэжлийн хүмүүсийг нь ажиллуулах, ор дэрийг нь бэлдэх, тэр орчныг нь бүрдүүлэх асуудал дээр болохоороо мөнгө нь байсаар байхад зарцуулалтыг нь хийлгэхгүй гээд. Энийг эс үйлдэхгүйгээрээ энэ оруулж ирсэн төсвөөрөө бид нар мансууралтыг дэмжиж байгаа байхгүй юу. Архидалтыг дэмжиж байна гэсэн үг. Ийм байж болох юм уу нөхөд өө? Тэгээд бүгд ингээд жижүүрийн хариулттай бас. Яг үнэндээ хэлэхэд ингээд ийм юм.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт. 9 Сангийн яам хариулъя. 9 дүгээр микрофон.

М.Санжаадорж: Аудитын байгууллагын төсвийг бол бид түрүүн хэлсэн яг хязгаартаа багтаагаад саналаа ирүүлсэн. Тэгээд 9 хувиар тэр цомхотгох зардлууд нь бас хасагдсан. Хөрөнгө оруулалтын зардал нь бол 2 тэрбум байж байгаад 1 тэрбум болоод буурсан ийм зүйл байгаа.

Мансууралттай холбоотойгоор бол бас нөгөө талдаа бол бид нар яах вэ тэр сангийн асуудал дээр шүүмжлэлийг хүлээж авч байна. Нөгөө талдаа мансууралтай холбоотойгоор бол бид нар хөрөнгө оруулалтын зардал 8.6 тэрбум төгрөг бас улсын төсвөөс санхүүжихээр тавьсан байгаа. Дээр нь Цагдаагийн ерөнхий газар дээр бол хар тамхитай тэмцэх тусдаа бол нэгж байгуулна гээд ярьсан байгаа. Үүнтэй холбоотой орон тоо, урсгал зардлыг нь бас тусгаж тавьсан байгаад байгаа. Тийм.

Д.Цогтбаатар: Сангийн яам тэгэхдээ энэ сая гишүүн яриад байгаа бичгээр тайлбар өгөх ёстой гэдэг. Тэрийг нь тэгээд өнөөдөртөө ердийн үед би өнөөдөр гэж шаардахгүй. Гэхдээ энэ чинь нэлээн эрт тавьчихаад шаардаад байгаа бол өнөөдөртөө багтаагаад өгч байх нь зөв байх гэж би зөвлөмөөр байна.

Миний зүгээс их асуух асуулт бас алга. Гэхдээ сая энэ юутай холбогдуулаад нэгдүгээрт, бид нар яг энэ Хууль зүйн байнгын хорооныхоо хүрээний асуудлуудыг л ярьж байх нь зөв. Тэгэхгүй энэ дээр хаа хамаагүй их олон өөр асуудлууд бас оруулж ирээд яриад байх нь хэцүү. Гэхдээ сая энэ багш нарын тухай асуудлыг ярьж байна. Энийг ингээд энэ Байнгын хороон дээр их улс төржүүлж яриад хэрэггүй байх. Нөгөө талаасаа би ч гэсэн өчигдөр СБД-ийн багш нарынхаа төлөөллийг хүлээж аваад энэ дээр нь би дэмжлэг үзүүлж байгаагаа тайлбарлаад явсан. Улсын Их, Засгийн газраас нэгэнт өргөн мэдүүлчихсэн байгаа болохлоор энэ удаадаа яг хүссэн хэмжээнд чинь биш гэхэд энийгээ яриа, хэлэлцээ явуулж байгаа максимум явуулж болох байх. Улсын Их Хурал дээр дэмжээд явна. Засгийн газар нэгэнт Их Хурал дээр өгчихсөн. Өөрсдөө энэ дээрээ бас Засгийн газар ойлгоод яриа, хэлэлцээнд орчихсон байгаа болохлоор Их Хурал энийг дэмжээд явах боломжтой байх. Харин хэмжээ хязгаар нь яг хуулийнхаа тэр өгөгдсөн хүрээнд бас байх ёстой. Энийгээ урт хугацаандаа өшөө яаж шийдэх вэ гэдэг энэ

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

өнцгөөсөө ярьж тал талдаа энийгээ аль болох бүрэн хангаж шийдэх тал дээр яриа, хэлэлцээгээр хуулийн хүрээнд явуулах нь зөв байх гээд яриад өнгөрсөн байгаа.

Сая энэ АМНАТ-ын асуудлыг ч ярьж байна. Энэ дээр би харин ёстой энд хуульчид сууж байгаа учраас нэг юмыг бодмоор байгаа юм. Энэ АМНАТ-ыг яг шинэ Үндсэн хууль батлагдсантай холбогдуулаад зөвөөр нэрлэхгүй бол хүмүүс ерөөсөө ойлгохгүй байгаа юм байна лээ. Энэ яриад байгаа гэдгийг нь. Тэгээд энэ чинь ёстой 6.2-т байгаа, Үндсэн хуулийн 6.2-т байгаа баялгийн эзэмшиж байгаа эзэмшигчийн авч байгаа төлбөр шүү дээ. Роялти гэдэг чинь яг тэр тухайн дээр үедээ гарсан томьёо нь тэр өмч хаадын өмч байсан. Тэр хаад тэр төлбөрийг газрын баялаг ашиглаад хаадад зүгээр тэр баялгийг нь ашиглаж байгаагийнхаа төлбөрийг шууд төлдөг байсан ийм л үндэс гарвальтай томьёо байгаа. Тэгэхлээр энийг ёстой харин газрын баялгийн өгөөжийн төлбөр гэж нэрлээд явбал зүгээр байж магадгүй. Энийг бас хуульчид бодно биз. Тэгэхгүй АМНАТ гэхлээр яг ямар үндэслэлээр бид нар энийг аваад байгаагаа хүн болгон мэддэггүй юм байна лээ. Тэгэхлээр энэ чинь Үндсэн хуулийн 6.2-ын чинь хэрэгжилт хэрэгжүүлэх арга хэлбэрүүдийн нь энэ шүү гэдгийгээ ойлгуулахад зөв байж магадгүй.

Тэр юун дээр ахиад ахин дахин хэлээд байна. Хууль зүйн байнгын хорооны хянаад баталсан төсвийг өөрчлөөд байхгүй шүү. Би энийг олон удаа сануулж хэлж байсан. Хууль зөрчих бол албан тушаалтнуудад үр дагаваргүй өнгөрдөг зүйл биш шүү. Хариуцлага хүлээх ийм механизм байгаа шүү гэдгийг бас сануулж хэлмээр байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо харин санал хураалтдаа энэ зарчмын зөрүүтэй 4 санал байж байгаа. Зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураана. Тэгэхлээр гишүүдийнхээ ирцийг бүрдүүлбэ манайхан энэ дээр ажиллаарай. Гишүүддээ хэлээрэй. Хүрэхээр байна уу? Санал хураалтдаа манайхан бэлдье.

Баасанжаргал гишүүний зарчмын зөрүүтэй санал байгаа.

1.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800633 төрийн, төслийн кодтой, Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшгийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 170 тэрбум биш ээ, 170 сая 899 зууны 7 сая төгрөг, 170 тэрбум юм байна шүү уучлаарай 899.7 сая төгрөг, 2026 онд санхүүжүүлэх дүн 25 тэрбум 635 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4 тэрбум 798 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Прокурорын газрын цахим хавтаст хэрэг, зөрчлийн системийн сервер, тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-аас, 2026 он, төсөвт өртөг 4 тэрбум 798 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 4 тэрбум 798 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал гэж байна. Энэ дээр тэгвэл дэмжье гэсэн томьёоллоор санал хураагаад явчих уу? Санал хураалт манайхан бэлэн үү? Дэмжээрэй.

38.9 хувиар энэ санал дэмжигдсэнгүй.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Үгүй харин тийм энэ чинь ажил чинь явахгүй л болчхож байгаа юм л даа. Тэгвэл явлаа шүү. Манайхан тэгэхдээ дэмжээрэй. Энэ өөрийнхөө салбарын юуг бид өөрсдөө унагаад байх дэмий л болов уу гэж би бодож байна.

2.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804408 төслийн кодтой, Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7км. /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 216 тэрбум 979.6 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 40 тэрбум төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 12 тэрбум 631.3 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Дүүргийн шүүхийн нэгдсэн барилга /Хан-Уул цогцолбор/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 75 тэрбум 254.5 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 28 тэрбум 666.5 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 12 тэрбум 631.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар. Энийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Одоо энэ дээр зогсоод яах вэ яах вэ тэгвэл тэгээд сайхан явдгаараа явцгаая.

3.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2101101137 төслийн кодтой, Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025 оноос 2028 он, төсөвт өртөг 546 тэрбум 556 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 121 тэрбум 721 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1 тэрбум 390 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны “Тарифт цалингийн жишиг шинэчлэн батлах тухай” 95 дугаар тушаал батлагдсантай холбогдуулан үүссэн зардлын зөрүү 1 тэрбум 111 сая төгрөг, Монгол Улсын дээд шүүхийн байр (Хангарди)-ны гадна фасадыг дулаалах, засварлах ажлыг гүйцэтгэх 279.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг тайлбар. Уянгахишиг гишүүн тайлбар хэлэх юм байна. Уянгахишиг гишүүний микрофоныг өгье.

Г.Уянгахишиг: Энэ дээр болохоороо Улсын дээд шүүх маань Хангарди байр руу нүүчихсэн байгаа. Хангардийн ажил нь хийгдчихсэн. Тэгэнгүүт хийгдчихсэн ажлаас энэ тэрбум 111 сая төгрөгийн зардал дутуу, өртэй байгаад байгаа юм байна. Тэгээд тэр нь төсөвт тусгагдаагүй. Мөн түүнчлэн 279 саяынх нь болохоор яг гадна фасадын ажлыг нь яг энэ хөрөнгө оруулалтыг хийж засварлахгүй бол галын аюулгүй байдлынхаа стандартыг хангахгүйгээс байгаад байгаа учраас дотор нь шүүх үйл ажиллагаагаа явуулж байгаа шүү дээ. Тэгээд бас академийн сургалт бүгд явж байгаа. Тэгэхээр энэ төсвийг баталж өгөх зайлшгүй шаардлагатай байгаад байгаа учраас нөгөө талаас Сангийн сайдын барилга байгууламжийн төсөл дундаас буюу гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монгол талын хөрөнгө оруулалтаас 150 тэрбумаас 1.3 тэрбумыг шийдэх асуудлыг Сангийн сайд өөрөө зөвшөөрчихсөн байж байгаа. Эх үүсвэр талаасаа. Тэгэхээр энэ саналыг дэмжээд өгөөрэй манайх.

Д.Цогтбаатар: Санал хураалт.

55.6 хувиар санал дэмжигдлээ. Дараагийн зарчмын зөрүүтэй санал.

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын урсгал зардлыг 300 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 300 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж. Та тайлбар хэлэх юм уу өөрөө? За за. Ингээд санал хураалт.

50 хувиар санал дэмжигдсэнгүй.

Номинчимэг горимын санал гаргая. Байгаагүй юм чинь энийг нь орхиё. Дараа нь ахиад бөөн маргаан гарна. Хууль зүйн байнгын хороон дээр ингээд хэрэггүй байх. Гэхдээ нэг юм уг нь Номинчимэг гишүүн ирцэд орсон байсан. Гэхдээ та үнэхээр саналдаа амжиж ороогүй болохлоор би энийг нь харсаар байж наад машин чинь улайх нь хамаагүй. Та сүүлдэж орж ирж байна шүү дээ. Тэгээд нэгдсэн чуулган дээрээ энэ юмнуудаа босгох юмнуудаа босгоцгооно биз.

Ингээд санал хураалтын дүнгүүдийг би сая танилцууллаа.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд гурав дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж Төсвийн байнгын хороонд танилцуулна. Байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа.

14.48 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ